**“ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЦАХИМ НЭГДСЭН НОМЫН САН” - ТӨСЛИЙН НЭГДСЭН ТАЙЛАН**

**2020 оны 02-р сарын 14-ний өдөр**

**I. Төслийн зорилго:**

Дээд боловсролын байгууллагын номын сангийн сургалтын баримтыг Цахимжуулах, нэгдсэн ангилал, мэдээллийн сантай болгох

**II. Төслийн товч мэдээлэл:**

- БСШУЯ-аас 2016 онд зарласан “Дээд боловсролын салбарын цахим нэгдсэн номын сан” төслийн хэлэлцүүлэгт Монголын номын сангийн холбоо-ТББ, МУҮНС хамтран оролцож энэхүү төслийг хэрэгжүүлэхээр шалгарсан.

**III. Төсөл гүйцэтгэхэд үндэслэсэн баримт**

- Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 301 дүгээр тогтоолоор баталсан "Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам"

төслийн тушаал.pdf

**Shutt-13/2016 –** гэрээний дугаартай “ДББ-ын цахим нэгдсэн номын сан”- 2016.12.13 оны захиалгат төслийн баримт

1. Баталсан: БСШУСЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан
2. Захиалагч: БСШУСЯ-ны ШУТБГ-ын дарга Т.Ган-Эрдэнэ
3. Санхүүжүүлэгч: ШУТС-ийн захирал Д.Энхжаргал
4. Гүйцэтгэгч байгууллага: МУҮНС-ийн захирал: Б.Ичинхорлоо
5. Төслийн удирдагч: Монголын номын сангийн холбооны тэргүүн Ж.Цэзэн

## IY. ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР /Техникийн даалгавар/

| № | Төслийн үр дүнгийн даалгавар | Тоо хэмжээ | Үр дүнгийн ерөнхий үзүүлэлт | Хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Их сургуулиудийн номын сангуудын ном сурах бичиг, гарын авлага, судалгааны ажлын тайлан, хичээлийн хэрэглэгдэхүүний нэгдсэн сан бий болгох /Номын сангуудийн хооронд цахим номын солилцоо хийх боломжтой байхаар/ | Монгол улсын Төрийн болон төрийн бус өмчийн 20 их дээд сургуулийн номын санг төсөлд хамруулна | МУҮНС-д ашиглаж буй монгол хувилбартай "Коха" программыг үндэслэн дээд боловсролын сургалтын материалын хайлтын системийг буй болгох | 2017-01-2019-02-р сар |
| 2 | Нэгдсэн сангаас номын мэдээллийг дэлгэрэнгүй гаргах хайлтын систем боловсруулах /номын нэр, зохиогч, агуулга, гарчиг, судалгааны ажлын өмнөх үг, агуулга гэх мэтийг харах боломжтой болгох/ | | 1. Олон улсын "Дьюигийн Аравтын Ангилал"-д шилжиж нэгдсэн индекс, кодтой болгох асуудлыг шийдвэрлэж зохиогч, номын нэр, төрөл, ISBN-ий дугаараар хайлт хийх сүлжээг буй болгох | 2017-01-2018-11-р сар |
| 3 | Нэгдсэн санд эх хувиар нь цахим хэлбэрт оруулсан номыг хуулбарлах, хэвлэх боломжгүй байх шийдлийг боловсруулах | | Эх хувиар цахимд ном оруулах асуудлыг сургуулийн удирдлагаар шийдвэрлүүлэх, баримтыг хуулбарлах, хэвлэх боломжгүй шийдлийг /"Flipping Book PDF Publisher Corporate v.5.8"/ программаар зохицуулна. | 2018-11-р сар |
| 4 | Ном, бусад хэвлэлүүдийг цахим шуудангаар захиалах, хүлээн авч ашиглах боломжтой захиалгын систем бий болгох | | Цахимд орсон номын тухай мэдээллийг нэгдсэн сүлжээгээр хайх, захиалгын дагуу тухайн номын санд очиж унших боломжыг судалж турших | 2018-11-р сар |
| 5 | Ховор ном зохиолыг цахим хэлбэрт шилжүүлэх, хадгалах, программ хангамжийн болон технологийн хялбар шийдлийг боловсруулах | | Цахим мэдээллийн нэгдсэн нөөцийг зөөврийн хард, CD болон цаасан хэлбэрээр хадгалах | 2019-2-р сар |

## Y. ТӨСЛӨӨР ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Дд | Төслийн хүрээнд гүйцэтгэх ажлын нэр | Хугацаа | Гүйцэтгэгчдийн овог, нэр, ажил | Тухайн шатны ажлын үр дүн |
|---|---|---|---|---|
| **2016 он** | | | | |
| **БЭЛТГЭЛ АЖИЛ** | | | | |
| 1 | Төсөл хэрэгжүүлэхийг дэмжсэн эрхзүйн орчин буй болгох /Монголын их дээд сургуулийн үүрэг оролцоог тодорхой болгох/ | 2016-12-5 | **Б.Ичинхорлоо** /МУҮНС-ийн захирал/ **Ж.Цэзэн** /МНС-ийн “Арван ухаан” Холбооны тэргүүн/ **Ж.Тунгалаг** /БМИУЗ-ийн мэргэжилтэн/ | 1. БСШУС-ын сайдын тушаал<br>2. Үндэсний номын сан-БМИУЗ, МНСХ-ны хамтарсан тушаал, албан тоот<br>3. Их дээд сургуулийн удирдлагын тушаал, албан тоот гарна |
| 2 | Төсөлд хамрагдах хүрээ, гүйцэтгэгч нарын судалгаа | 2016-10-11 сар | **1.МУҮНС<br>2. МНС-ийн “Арван ухаан” холбоо** | Цахим программ, ДАА -ын өнөөгийн байдлыг социологийн судалгаагаар тодруулж, цаашид ажил гүйцэтгэх дадлага туршлагатай хүн шилж ажиллуулах боломж бүрдэнэ |
| 3 | Материаллаг бааз бүрдүүлэх судалгаа хийх | 2016-11-25 | | Гүйцэтгэгч болон хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн бааз суурьтай болно |
| 4 | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх орчны судалгаа, туршилт, | Төслийн явцад | | |
| 5 | Энэхүү төслийн үйл ажиллагаанд ДББ-ын нийт номын сангуудын бие даасан оролцоог нэмэгдүүлэх ажил | | | Төсөлд хамрагдаагүй номын сангуудыг сургалтанд үнэ төлбөргүй нэгэн адил хамруулж, заавар зөвлөгөө өгснөөр цаашид бие дааж ажиллах боломж бүрдэнэ |
| 6 | Цаашид тогтвортой хөгжүүлэх ажлын талаар хэлэлцүүлэх, санал солилцох, гадаадын туршлага судлах, асуудал дэвшүүлэх | | | ДББ-ын нийт номын сангууд нэгдсэн бодлого, шийдвэрт хүрэх боломж бүрдэнэ |
| **Төсөл хэрэгжүүлэх эхний шатны ажлын төлөвлөгөө** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Төслийн багийн уулзалт, хуралдаан, хэлэлцүүлэг | 2016-09-30 | **Б.Ичинхорлоо** /МУҮНС/ **Б. Бат-Эрдэнэ** /МУҮНС-ийн бүртгэлийн мэргэжилтэн/ **Ж.Цэзэн** /МНСХ/ **Ж.Тунгалаг** /БМИУЗ/ | Номын сангийн консерциумын гишүүдтэй санал солилцох уулзалтаар хамтарч ажиллах эсэх шийдэлд хүрнэ |
| | | 2016-10-р сар | | МУҮНС-ийн "Коха"цахим программтай танилцаж, төслийг хэрхэн хэрэгжүүлэх шийдвэрт хүрэх |
| | | 2016-12-р сар | | Талуудын гүйцэтгэх ажлын хэлэлцүүлэг, гэрээний баримт бичиг үйлдэх, дахин хянах |
| **2017 он** | | | | |
| 1 | МУҮНС-д боловсруулан ашиглаж буй болон зарим Их дээд сургуулийн номын сангийн "Коха" программын бүтэц өгөгдлийн талаар судалгаа хийх | 2017-01-05 сар | **1. Б. Бат-Эрдэнэ** /МУҮНС-ийн бүртгэлийн номын санч-"Коха" программ нутаг-шуулах ажил хариуцагч/ **2. Г.Баяртуяа** /МУҮНС-номзүйч, коха хариуцагч/ **3. Бат.Тунгалаг** /МУҮНС-ийн сан хөмрөгийн хэлтсийн дарга/ | МУҮНС-ийн ашиглаж буй монгол хувилбартай "Коха" болон Их дээд сургуулийн одоогийн программын давуу, сул талын талаар хэлэлцэж тайлан бичнэ |
| 2 | Номын сангийн "Коха" программ болон нэгдсэн ангилал, тулгамдаж буй бусад асуудлаар сургалт уулзалт зохиох ажлууд | 2017-4-5 сард | | ДББ-ын номын санд МУҮНС-ийн "Коха"-гийн шинэ хувилбараас нэвтрүүлэх ажлын суурь тавигдана. Төсөлд хамрагдах сургуулиудыг сонгоно. |
| 3 | Монголын Их дээд сургуулийн номын сангийн ангиллын одоогийн байдлын судалгаа | 2017-1-2 сар | **Ж.Цэзэн** **Э.Оюунгэрэл** /АШУИС-ийн номын сангийн | Төсөлд хамрагдсан сургуулиудын номын сангийн ОУ-ын ангиллын өнөөгийн байдлын дүгнэлт, тайлан гарна |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Номын сангийн ангиллын талаарх хэлэлцүүлэгт бэлтгэх | 2017-05 сард | эрхлэгч/ **Бат.Тунгалаг** | Ангиллын нэгдсэн индексээр цахимд өгөгдөл оруулах, хайх боломж бүрдэнэ |
| 5 | ДББ-ын цахим номын сангийн олон улсын чиг хандлагыг судлах | 2017-с 2018 онд үргэлжилнэ | **МНСХ** | Европын зарим нэр хүнд бүхий их, дээд сургуулийн номын сангийн хөгжлийн чиг хандлагын талаар тайлан бичиж танилцуулна |
| 7 | “Коха” программын бүтэц өгөгдлийн нэмэлт боловсруулалт, сонголт хийх. | 2017-6 сар | **МУҮНС<br>1. Б. Бат-Эрдэнэ<br>2. Г.Баяртуяа** | “Коха” программын бүтэц өгөгдлийн нэмэлт боловсруулалт, давуу талыг өөрчлөн ашиглах боломжийг тусгасан баримт буй болж цаашид мөрдөх |
| | | 2017-04 сар | | “Коха” цахим программын талаарх сургалт, семинар-I |
| | | 2017-05 сар | | “Коха” программ ашигладаг номын сангуудын инженерүүдийн уулзалт , сургалт, семинар-II-р хэлэлцэж аргазүйн зөвлөмж, гарын авлага бэлэн болно |
| 8 | Монголын Их дээд сургуулийн номын сангийн ном баримтыг ДАА-аар ангилах, программаас нэгдсэн ангиллаар хайлт хийх боломж бүрдүүлэх | 2017-с 2018 онд үргэлжилэх | **Ж.Цэзэн<br>Э.Оюунгэрэл<br>Бат.Тунгалаг<br>Б.Бат-Эрдэнэ** | Бусад ангиллаас “ДАА”-руу ном хөрвүүлэх боломжит арга зөвлөмж гаргах /MARC/, зөвлөх |
| | | | | “ДАА”-аар ном ангилах, ерөнхий ба тусгай цуврал гарын авлага боловсруулж гаргана |
| 9 | Бусад Их дээд сургуулийн номын сангуудад энэхүү төслийн хүрээн дэх үйл ажиллагааг сурталчилах, цаашид бие дааж ажиллах орчин бүрдүүлэх | 2017-с 2018 онд үргэлжилнэ | **Ж.Цэзэн<br>Ж.Тунгалаг** | Төсөлд хамрагдаагүй Бусад их дээд сургуулийн номын санчдын төлөөллийг төслийн сургалтанд үнэ төлбөргүй хамруулж зөвлөгөө өгөх, гарын авлагаар хангах |

| **2018 он** | | | | |
|---|---|---|---|---|
| **ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАРЫН ДАГУУ ХИЙХ ҮНДСЭН АЖИЛ** | | | | |
| 1 | Төсөлд хамрагдсан их дээд сургуулийн номын сангуудын ном сурах бичиг, гарын авлага, судалгааны ажлын тайлан, хичээлийн хэрэглэгдэхүүний нэгдсэн сан бий болгох | 2018 оны 5-11 сар | **1. Б. Бат-Эрдэнэ**<br>**2. Г.Баяртуяа ба бусад**<br>**3. Их дээд** сургуулийн номын сангийн эрхлэгчид | Төсөлд хамрагдсан их дээд сургуулиудын номын сангийн сургалтын материалыг цахимд хөрвүүлэх ажил хийгдэнэ. Ажлын гүйцэтгэлийн тайлан бичиж хэлэлцүүлэх, санал дүгнэлт гаргах |
| | Номын сангуудийн хооронд цахимаар номын тухай мэдээллийн солилцоо хийх боломж буй болгох | | | Төсөл хэрэгжсэнээр номын сан хоорондын мэдээлэл солилцох ажилд гарсан давуу тал, цаашдын чиг хандлагын талаар санал дүгнэлт гаргах, тайлагнах |
| 2 | Нэгдсэн сангаас номын мэдээллийг дэлгэрэнгүй гаргах хайлтын систем боловсруулах */номын нэр, зохиогч, агуулга, гарчиг, судалгааны ажлын өмнөх үг, агуулга гэх мэтийг харах боломжтой болгох/* | 2018 оны 12 сар хүртэл | **Бат.Тунгалаг**<br>**Б.Бат-Эрдэнэ**<br>**Г.Баяртуаяа** | Олон улсын номын сангийн нэгдсэн ангиллын (ДАА) дагуу зохиогч, номын нэр, төрөл, ангиллын индекс, ISBN- ээр хайлт хийх ажлын бодит байдлыг цонхон дээр харуулж, гүйцэтгэлийг тайлагнах, хэлэлцүүлэх, санал дүгнэлт гаргах |
| 3 | Нэгдсэн санд эх хувиар нь цахим хэлбэрт оруулсан | 2017-с 2018 онд үргэлжилнэ | **Тухайн сургуулийн номын сангийн эрхлэгчид** | Эх хувиар номыг цахимд оруулах ажлыг тухайн сургууль бие дааж гүйцэтгэх үндэслэлийг гаргах, зөвлөх, тайлагнана |
| | Номыг хуулбарлах, хэвлэх боломжгүй байх шийдлийг боловсруулах | | **Б.Бат-Эрдэнэ**<br>**Г.Баяртуаяа** | Эх хувиар цахимд орсон номын хадгалалт хамгаалалтын талаар “Flipping Book PDF Publisher Corporate v.5.8” программаар хэрхэн шийдвэрлэх аргазүйн зөвлөмж гаргах |
| 4 | Ном, бусад хэвлэлүүдийг захиалах, хүлээн авч ашиглах боломжтой захиалгын систем бий болгох | | | Ном, баримтын тухай мэдээллийг цахимаар хайх, захиалга өгөх, тухайн номын санд очиж унших боломжыг буй болгож, журам гаргах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | Ховор ном зохиолыг цахим хэлбэрт шилжүүлэх | | **Тухайн сургуулийн номын сангийн эрхлэгчид** | Ховор номыг цахимд оруулах ажлыг тухайн сургууль бие дааж гүйцэтгэх үндэслэлийг гаргаж зөвлөх |
| | Мэдээллийг хадгалах, программ хангамжийн болон технологийн хялбар шийдлийг боловсруулах | | **Б.Бат-Эрдэнэ Г.Баяртуяа** | Цахим мэдээллийн нэгдсэн нөөцийг зөөврийн хард, CD болон цаасан хэлбэрээр хэрхэн хадгалах аргазүйн зөвлөмж гаргах |
| **ТӨСӨЛД ХОЛБОГДОХ НЭМЭЛТ АЖИЛ** | | | | |
| 6 | **Олон улсын номын сангийн нэгдсэн ангилалд (ДАА) бүрэн шилжиж нэг ижил индексээр хайлт хийх боломж бүрдүүлэх** | 2017-2018 | **Ж.Цэзэн Э.Оюунгэрэл Бат. Тунгалаг** | Төсөлд хамрагдсан сургуулийн номын сангуудын ангиллын талаарх гарын авлага зөвлөмж гаргах явцын тайланг бичих |
| 7 | **МУҮНС-ийн санд хадгалагдаж буй** (XX-XXI зуун) **11.500 орчим докторын диссертаци ба хураангуйг Коха программд оруулах ажлыг хийж турших** | 2017-2018 | **Т.Билэгбаяр** /номын сан судлал мэргэжлийн оюутан/ **Бат. Тунгалаг Б.Бат-Эрдэнэ** ба бусад | 1.Уг ажлыг хэрхэн хийсэн тухай арга, туршлага, тоо баримт, саад бэрхшээл, бусад номын сангуудад санамж болох санал зөвлөмж бүхий бичгийн тайлан гарна<br>2.Гарын авлага бэлтгэж хэвлүүлэх |
| **ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ БУСАД АЖЛУУД** | | | | |
| 8 | Төсөлд хамрагдсан сургуулийн номын сангуудад социологийн судалгаа явуулах | 2017-2018 | **Бат.Тунгалаг** | “Цахим номын сан”-гийн төсөл хэрэгжүүлэхэд санал асуулгын нэгдсэн дүгнэлт бүхий баримт буй болно |
| 9 | Шат дараалсан сургалтуудыг зохион байгуулна / Сургалт-I, II, III/ | 2017-2018 | **Ж.Тунгалаг Бан. Тунгалаг** | Сургалт-I-р өнөөгийн байдлыг судалж, хэлэлцэнэ.<br>Сургалт-II-р “Коха” программын мэргэжилтнүүдийн санал дүгнэлтэнд үндэслэнэ.<br>Сургалт -III р төслийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж дүгнэнэ |
| 10 | Төслийн хүрээнд хийгдсэн ажлаар нийт номын сангуудад зөвлөмж | 2017-2018 | **Ж.Цэзэн Э.Оюунгэрэл** | Цахим номын сангийн хайлт, үйлчилгээтэй холбоотой гарын авлагуудыг боловсруулж |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | гарын авлага бэлтгэж хэвлүүлэх ажил хийнэ | | | ашиглалтанд гаргана |
| 11 | Гадаад, дотоодын дээд боловсролын салбарын цахим номын сангийн туршлага судлах | 2017-2018 | **Ж.Цэзэн Б.Бат-Эрдэнэ** | Төслийн үр дүнг цаашид боловсронгуй болгоход зөвлөмж болохуйц ажлын туршлага, хөгжлийн чиг хандлагыг үзэж судлан тайлагнах |
| 12 | Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой судалгааны тоног төхөөрөмж, компьютерийн программ хангамж, үйлчилгээ үзүүлэх ажил | 2017-2018 | **МУҮНС МНСХ** | Техник хэрэгсэл худалдан авах, цахим программаар хангах, үйлчилгээ үзүүлэх зэргээр хийсэн ажлын бичвэрийн тайлан гарна |
| 13 | Төслийн тайланг боловсруулан бичих, хүлээлгэн өгөх ажил: | 2018-12-25 | **Ж.Цэзэн Б.Ичинхорлоо Э.Энхзул** /МУҮНС-ийн нягтлан бодогч/ | 1. Төслийн үндсэн болон нэмэлт шаардлагатай ажлуудын гүйцэтгэлийн мониторигийн ба дэлгэрэнгүй тайланг тухай бүр бичиж, нэгдсэн тайланг боловсруулан, баримт нотолгоог хавсран бичиж Төслийн захиалагчид хүлээлгэн өгнө.<br>2. Төслийн санхүүжилтийн тайлан; |

## ҮI. ТӨСЛӨӨР ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОВЧОО

| № | Үр дүнгийн даалгаварын дагуу хийсэн үндсэн ажил | Гүйцэтгэл | Хариуцсан ажилтан | Цаашдын төлөв хандлага |
|---|---|---|---|---|
| **I** | **Нэг.**<br>**МУҮНС-ийн "Коха" программд үндэслэн Их дээд сургуулийн номын сангийн сургалтын** | 1.Сургуулийн тоо-20. (Гүйцэтгэл 100 %)<br>2.Сургууль тус бүрийн номын сангийн сургалтын хэрэглэгдэхүүнийг судлан, **19.405** ширхэг сургалтын хэрэглэгдэхүүн, МУҮНС-ийн **11.577** ширхэг докторын диссертаци, нийт **31,000** баримтыг нэг бүрчлэн, шат дараалан хөрвүүлж "Эрдэм судлал" нэртэй мэдээллийн санг буй болголоо. | **Б.Бат-Эрдэнэ Б.Баяртуяа Н.Мөнхцэцэг** | * МУҮНС-ийн 11577 нэгж нэрийн диссертацийн баримт оруулсан туршлага, загвараар бусад номын сангууд сургалтын баримтаа өгөгдлийн дагуу цахимжуулах боломжтой гэж дүгнэж байна |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | **хэрэглэгдэхүүний нэгдсэн сан бий болгох.** *(каталогийн мэдээлэл солилцох)* | 3.Төсөлд хамрагдсан 20 их дээд сургуультай, хамтран ажиллах гэрээ байгуулж, цаашид ажиллах орчинг бүрдүүлэв. Мөн ЧД-ийн Номын өргөө, ХУД-ийн лаборатори 18-р сургууль, ЧД-ийн лаборатори 23-р сургуулийг загвар болгон авч хүсэлтийн дагуу төслийн сүлжээнд хамрагдах эрх нээж ажил эхлүүлэв | **МУҮНС** | * "Коха" –г дэмждэг номын сангийн тоо нэмэгдэх хандлагатай (ЧД-16 ЕБС, Баянгол дүүргийн 27 ЕБС, орон нутгийн номын сан г.м.) |
| | | 4. 30 гаруй их дээд сургуулийн 60 гаруй номын санчдын дунд сургалт явуулж санал асуулгыг үндэслэв. /2017.04.17/<br>5."Коха" программ хэрэглэгч номын сангуудын IT инженерүүдийн сургалт-уулзалт /2017.05.19/<br>6. "ДБЦННС" төслийн хэрэгжилтийн үр дүнгийн сургалт-III. /2019.03.12/ | **Төслийн багийн гишүүд** | * Төсөлд хамрагдсан бүх сургууль нэгдсэн сүлжээнд холбогдож, Цаашид сургалтын материал, бусад ноот, газрын зураг зэрэг өвөрмөц хэлбэрийн хэвлэлийн бүтээгдэхүүнийг Кохад оруулах хичээлийг эрх авсан номын санчдад зааж сургав |
| **II** | **Хоёр.**<br><br>**Нэгдсэн сангаас зохиогч, номын нэр, төрөл, агуулга, ISBN-ий дугаараар хайлт хийх сүлжээг буй болгох** | (Гүйцэтгэл 100 %)<br>1. Нэгдсэн санд бүрдүүлсэн номзүйн мэдээллийг Z39.50 стандартыг ашиглан гадаад дотоодын аль ч номын сан, уншигч каталогийн мэдээлэл солилцох боломж бүрдлээ.<br>2.МУҮНС-ийн "эрдэм судлал" сангаас номын зохиогч, нэр, өмнөх үг, аль сургуульд ямар мэргэжлээр эрдмийн зэрэг хамгаалсан зэрэг бусад мэдээллийг бүрэн харах боломжтой | **Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа**<br><br>**Эмхтгэсэн. Ж.Тунгалаг** | * Z39.50 стандартын хэрэглээ, ашиглалтыг боловсронгуй болгох зөвлөмж, гарын авлага гаргах шаардлагатай. *(нэгдсэн ангилал, индексийн мэдээлэл солилцоход, ж-нь: Z39.50-ийг тогтмол ажтиллагаатай байлгах)* |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 3.МУҮНС-д боловсруулан нэвтрүүлж буй “Коха” программын өгөгдлийн дагуу номыг олон янзаар хайх цонх бүхий системийг боловсруулж сургалтаар хэлэлцүүлэв.<br>4.”Дээд боловсролын сургалтын байгууллагын эрдэм судлалд туслах цахим мэдээллийн сан”. УБ., 2017 он гарын авлага гаргаж нийтийн хүртээл болгов | | *Үргэлжлэл*<br>* MARC–21 стандартаар номзүйн мэдээлэл оруулах зөвлөмжийг боловсруулах шаардлагатайг төслийн сургалтаар нийт номын санчид санал гаргав. |
| **III** | **Гурав.**<br>**Нэгдсэн санд эх хувиар нь цахим хэлбэрт оруулсан номыг хуулбарлах, хэвлэх боломжгүй байх шийдлийг боловсруулах** | (Гүйцэтгэл-100 %)<br>1.Цахимд бүрэн эхээр оруулж ашиглах номыг сургуулийн удирдлага зохиогчтой гэрээ байгуулсны үндсэн дээр хийгдэнэ.<br>2.Цахимд зөвшөөрөгдөн орсон тухайн номыг хуулбарлах, хэвлэх боломжгүй шийдлийг /“Flipping Book PDF Publisher Corporate v.5.8”/ программыг ашиглан зохицуулна. *(ашиглалтын лицензийг сургууль хариуцана)*<br>3.Ховор хуучин номын судалгааг сургууль тус бүр гаргаж шаардлагатай гэж үзвэл программд оруулахаар болов | **Б.Бат-Эрдэнэ**<br>**Г. Баяртуяа** | Үүний дагуу ховор хуучин номын нэрсийг гаргуулах ажлыг хийв.<br>(ЭМШУИС-ийн “Ховор” номын нэрсийг жишээг хавсралтад үзнэ үү) |

<table>
<tr><td rowspan="2">IY</td><td rowspan="2">Дөрөв.<br>Ном, бусад хэвлэлүүдийг цахим шуудангаар захиалах, хүлээн авч ашиглах боломжтой захиалгын систем бий болгох</td><td>(Гүйцэтгэл-100 %)<br>1.Төслийн хүрээнд “Эрдэм судлал” цахим нэгдсэн мэдээллийн сан буй болсон нь цаашид сургууль тус бүр шаардлагатай номыг бүрэн эхээр цахимжуулах суурийг тавьж өглөө. (Гүйцэтгэл-100 %)<br>2.Цахимаар ном захиалж унших сонирхол ихээхэн нэмэгдэж байна.<br>Иймд Дээд боловсролын хүрээнд дараах эрхзүйн орчинг зохицон шийдвэрлэх шаардлагатай:</td><td>Б.Бат-Эрдэнэ<br>Г. Баяртуяа</td><td>* МУҮНС төвтэй мэдээллийн нэгдсэн санд холбогдож, алслагдсан орон зайнаас хайлт хийх хэрэгцээ өндөр болжээ.<br>* Иймд Нэгдсэн санд тулгуурлан мэдээ, мэдээлэл боловсруулах, олон улсын ангиллын индексийг бусад номын сангууд авч ашиглах ажлыг дэмжих;<br>* Дээд боловсролын “Нээлттэй номын сан”-ийн хүрээнд:<br>а/ Зохиогчийн эрхийн зөвшөөрлөөр цахим ном унших</td></tr>
<tr><td>а/. Зохиогчийн гэрээ, сургуулийн удирдлагын шийдвэрээр бүрэн эхээр цахимд орсон баримтаас Лавлагааны номын санч захиалагчид илгээх эрх үүсгэх;<br>б/. Бусад номын санд цахимаар суудал захиалж, өөрийн бичиг баримтаар унших боломжийг сургууль хооронд шийдвэрлэх;</td><td></td><td>(Ж-нь: цахим уншилагын хугацаа, номын хэмжээ, төлбөрийн % тогтоох г.м.)<br>б/ Аль ч номын санд оюутан унших эрхтэй байх<br>в/ “ховор ном”-ын нэрсийг тогтоох</td></tr>
<tr><td>Y</td><td>Тав.<br>Ховор ном зохиолыг цахим хэлбэрт шилжүүлэх, хадгалах, программ хангамжийн болон технологийн хялбар шийдлийг боловсруулах</td><td>(Гүйцэтгэл-100 %)<br>Цахимд орсон “Ховор ном, баримт”-ыг сүүлийн үеийн дэвшилтэт, энгийн зөөврийн төхөөрөмжийг ашиглан архивлах боломжтой</td><td></td><td>* “Ховор ном, баримт”-ын нэрсийг сургуулийн захиргааны шийдвэрээр тогтооно.<br>* Үүлэн (cloud) технологийг ашиглах<br>*E-PUB – ашиглах (сонсдог болон уншдаг /брайл/ ба бусад хувилбар.</td></tr>
<tr><td colspan="5">YII. ТӨСӨЛД ХОЛБОГДОХ НЭМЭЛТ АЖИЛ (Гүйцэтгэл 100% )</td></tr>
</table>

<table>
<tr><th>№</th><th>Нэмэлт ажлын нэр</th><th colspan="3">Нэг ангилал, индекстэй болох хэрэгцээ</th></tr>
<tr><td rowspan="4">YI</td><td rowspan="4">Олон улсын номын сангийн нэгдсэн ангилалд (ДАА) бүрэн шилжиж нэг ижил индексээр хайлт хийх боломж бүрдүүлэх</td><td colspan="3">* Дэлхийн 200 гаруй улс орноос Монгол улс ДАА буюу олон улсын ангиллыг авч хэрэгжүүлсэн 136 дахь улс болсон /БСШУС-ын Сайдын 2001 оны 180-р тушаал бий/ хэдий ч, бүрэн, зөв индекс олгогдохгүй байна.<br>*Нэг номыг өөр өөр индекстэй ангилж байгаа нь Төслийн даалгаварын 2-т заасан хайлтыг хийхэд төвөг учруулж байна.</td></tr>
<tr><td colspan="3">* Гадаадын номын санд бүрдүүлсэн монгол номын ангилал гологдож байна. /жишээ бий/<br>*Номын олон улсын дугаарын /ISBN/ зохицуулалт шаардлагатай. (зохиогч бүр ISBN авахгүй байгаа нь олон улсад Монгол ном бүртгэгдэхгүй байх шалтгаан болж байна)<br>*Номыг ангилах шинжлэх ухааны тогтсон индекс, зохиогчийн тэмдэгт, дугаар нь олон улсад мэдээлэл солилцох ТҮЛХҮҮР юм.<br>*Олон улсын жишигт хүрч хөгжихөд номын сан бүр Нэг номыг нэг ижил индекстэй болгох шаардлагатай</td></tr>
<tr><td>Төсөлд хамрагдсан их дээд сургуулийн ангиллын өнөөгийн байдлын судалгаа:</td><td>Хариуцсан ажилтан</td><td>Цаашдын төлөв хандлага</td></tr>
<tr><td>* Их дээд сургуулиудийн номын сангийн 90 гаруй %-нь олон улсын ангиллыг ашиглаж байна.<br>*Төсөлд хамрагдсан 20 их дээд сургуулийн 18 нь олон улсын ангилалтай, 2 нь Орос улсын ангилалтай байв<br>* МУИС, БАИС-ийн номын сан Орос улсын ангиллаас ДАА-д шилжин ажиллаж байна.</td><td>Ж.Цэзэн<br>Э.Оюунгэрэл<br>Бат.<br>Тунгалаг</td><td>*БСШУСЯ-аас гаргасан 2001 оны 180 тоот тушаалыг Монголын нийт номын санг хамааруулан шинэчилж гаргах;<br>*МУҮНС-ийн дэргэд “Нэгдсэн ангилал”-ын индекс ба ISBN-ы дугаар олгож ажиллах, “Монгол ном”-ын мэдээллийн баазыг бүрдүүлэх шийдвэр гаргах;</td></tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | **Олон улсын ДАА-р ном ангилах аргазүйн гарын авлагыг хэвлүүлж нийтийн хүртээл болгов:** ***(Сургалтын баримтанд хойно үзнэ үү)***<br>1.“ДАА-ын хураангуй”. УБ.,2017<br>2.“ДАА-аар ном ангилах ерөнхий аргазүй”.-2018<br>3.“ДАА-аар салбар шинжлэх ухааны ном ангилах аргазүйн зөвлөмж”.-2018 | | Бусад төрлийн номын сангууд олон улсын ДАА-д нэгдэн орох саналыг гаргаж байна.<br>* Орон нутгийн нийтийн номын сангууд болон УБ хотын дүүргийн ЕБС-ийн 20 гаруй номын сан ДАА-д шилжиж эхэлсэн |
| **YII** | **МУҮНС-ийн санд хадгалагдаж буй** (XX-XXI зуун) **11.500 орчим докторын диссертаци ба хураангуйг Коха программд оруулах ажлыг хийж турших** | **(Гүйцэтгэл 100% )**<br>*МУҮНС-ийн санд хадгалагдаж буй (XX-XXI зуун) 11.577 орчим докторын диссертаци ба хураангуйг Коха программд оруулж дуусав.<br>*Уг ажлыг 2017-2018 онд хийж 2018.12.17-д МУҮНС-д хүлээлгэж өгөв.<br>*Гэрээт болон туслах ажилтан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллав<br>*.”МУҮНС-ийн “Коха” программ ба цахим диссертаци”. УБ., -2018 он гарын авлага бэлтгэж хэвлүүлэв | **Т.Билэгбаяр Бат.Тунгалаг Б.Бат-Эрдэнэ ба бусад** | Уг ажлыг хэрхэн хийсэн тухай арга, туршлага, тоо баримт, саад бэрхшээлийн талаарх санал зөвлөмж бүхий гарын авлагыг гаргаснаар ийг хэлэлцүүлж, бусад номын сангуудад загвар санамж болох санал бүхий бичгийн тайлан гарна |

**YIII. ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ БУСАД АЖЛУУД**

| № | Нэмэлт ажлын нэр | Гүйцэтгэл 100% | Хариуцсан ажилтан | Цаашдын төлөв хандлага |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| **1** | Цахим программ хангамжийн талаарх судалгаа хийх | “Цахим номын сан”-гийн төсөл хэрэгжүүлэхэд номын санчдын санал хүсэлтийг судлах зорилгоор Социологийн судалгаа –I, II, III,IY,Y –ыг төлөвлөн шат дараалалтай явуулж нэгтгэн дүгнэснээр цаашдын чиг баримжаа гаргах, хамтран хийх ажил амжилттай болсон | **Бат.Тунгалаг** | Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг судлах, хангах асуудлаар номын сан бүр шинэчилсэн судалгааг тогтмолжуулах болов |
| **2** | Төслийн ажлын эхлэл, явц, үр дүнгийн талаар шат дараалсан Сургалтуудыг зохион байгуулах, асуудлыг хэлэлцэх шаардлагатай гэж үзэв | 2017 оны 04-17-нд Сургалт-I-ийг зохион байгуулж, 60 гаруй номын санчдын дунд хэлэлцүүлэг санал авсны үндсэн дээр төсөлд хамрагдах хүсэлтэй их дээд сургуулийн номын сангуудыг сонгон тогтов. МУҮНС-аас албан тоот явуулж төслийн үйл ажиллагааны эрхзүйн орчин бүрдүүлж, үйл ажиллагааг эрчимжүүлэв | **Ж.Тунгалаг<br>Бан. Тунгалаг** | Аль ч сургуулийн удирдлага номын сангийн үйл ажиллагааг дэмжих талаар сул, сургуулийн хавсрага ажлын шинжтэй байсан хэдий ч сүүлийн жил харьцангуй ойлголт оролцоотой болсон. |
| | | 2017 оны 05-р сарын 19-нд Сургалт-II-ыг Улаанбаатар хотын төв номын санг түшиглэн зохион байгуулж, “Коха” программ ашигладаг номын сангуудын IT инженер, мэргэжилтнүүдийн семинар-ярилцлага хийв. | **Б.Бат-Эрдэнэ<br>Г.Баяртуяа<br>Бат.Тунгалаг** | Номын сангийн IT инженер, цахим каталогчид Коха программыг бүрэн монголчилж нийтээр ашиглах шаардлагатай гэж үзэв |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 2019 оны 03-р сарын 15-д Сургалт –III-ыг СУИС-ийн Соёлын сургуулийн номын санг түшиглэн зохион байгуулж, төслийн явц, практик үр дүнгийн талаар хамтран хэлэлцэж, цахимд мэдээлэл үүсгэх сургалт явуулав. Төслийн хүрээний их дээд сургуулиас гадна ЕБС-ийн номын санчид оролцож 3 сургуульд эрх олгов. | **Ж.Тунгалаг Бат.Тунгалаг Б.Бат-Эрдэнэ** | Монголын нийт номын сангууд нэгдсэн нэг программтай байхыг чухал гэж үзэж байна. Монгол хувилбартай Кохад нэгдэх, бусад номын сангуудтай сүлжээгээр мэдээлэл солилцох шаардлагатай тул нэгдсэн сургалт хийх, зөвлөмж, гарын авлагаар хангах саналтай байв |
| **3** | Төслийн хүрээнд хийгдсэн ажлаар нийт номын сангуудад зөвлөмж гарын авлага бэлтгэн хэвлүүлж түгээх | Цахим номын сангийн хайлт, үйлчилгээтэй холбоотой Сургалт-I, II, III-ын илтгэл хэлэлцүүлгийн эмхтгэл болон цахим номын сангийн үйл ажиллагааг хөтлөн явуулахад тус дөхөм болох бусад гарын авлагуудыг бэлтгэж гаргав | **Ж.Цэзэн Э.Оюунгэрэл** | Цаашид программын өгөгдөл хийгээд бусад ажил тус бүрээр зөвлөмж гарын авлага боловсруулан ашиглах нь илүү ач холбогдолтой гэж номын санчид үзэж байна |
| **4** | Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой судалгааны тоног төхөөрөмж, компьютерийн программ хангамж, үйлчилгээ үзүүлэх ажил хийх | Техник хэрэгсэл худалдан авах, цахим программаар хангах, үйлчилгээ үзүүлэх, сургалт, судалгаа, тайлангийн танилцуулга, бичиг баримт хэвлэж олшруулах г.м. төслийн үйл ажиллагаанд чухал шаардлагатай Өнгөт принтер, зөөврийн компьютер, хард, каталогийн шүүгээ, бичиг хэргийн бусад холбогдох материалаар хангаж амжилттай ажиллаа | **МУҮНС МНСХ** | Төслийн хэлэлцүүлгийн анхан шатанд санхүүжилтийн задаргааг сайтар судалж зөв хийх, задаргааны дагуу хувиарлан ажиллах ажилд анхаарч ажиллах нь чухал байв |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **5** | Гадаад, дотоодын дээд боловсролын салбарын цахим номын сангийн туршлага судлах | * Төслийн үр дүнг цаашид боловсронгуй болгоход зөвлөмж болохуйц ажлын туршлага, хөгжлийн чиг хандлагыг үзэж судлах, нийтэд тайлагнан танилцуулах үүднээс гадаад томилолтоор төслийн багийн удирдагч Ж.Цэзэн ХБНГУ-ын 2 их сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж ажиллав. /Хавсралт/<br>* Олон улсын MARC-21 форматыг дэмжигч “Коха” программын ашиглалт”-2018. Гарын авлага хамтран гаргав | **Ж.Цэзэн** | 1. Номын сангийн цахим программ хангамжийг хариуцах инженерийн баг бүхий тусгай төвийг МУҮНС-ийн дэргэд буй болгох;<br>2. Цаасан каталогийг тасралтгүй хөтлөх, хадгалах; |
| | Төсөлд хамрагдсан 20 их дээд сургуулийн номын сангуудаар тогтмол явж ажиллах | Төсөлд хамрагдсан 20 их дээд сургуулийн номын сангуудаар явж цахим программын судалгаа хийх, сургалтын материал хөрвүүлэх, МУҮНС-ийн “Эрдэм судлал” мэдээллийн санд нэвтрэх эрх олгох, үр дүнг хянах ажлууд тогтмол хийгдлээ. | **Б.Бат-Эрдэнэ<br>Г.Баяртуяа<br>Н.Мөнхцэцэг** | МУҮНС зэрэг томоохон төвлөрсөн номын сангуудад тусгай цахим инженерийн баг ажиллах шаардлагатай гэж үзэв |
| **6** | Төслийн тайланг боловсруулан бичих, хүлээлгэн өгөх ажил: | * Төслийн хугацаанд 2 удаа биетээр илтгэн хэлэлцүүлэв:<br>а/ 2017 оны 06-р сарын 14-д МУҮНС дээр ШУТС-ийн төсөл хариуцагч 5 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид, төслийн багийн гишүүдэд төслийн явцын талаар илтгэн хэлэлцүүлэв.<br>б/ 2018 оны 01-31-д БСШУСЯ, ШУТС-ийн захиалгат төслийн баг хамт олонд “ДБЦННС” төслийн явц, үр дүнгийн талаар илтгэн танил-цуулж хэлэлцүүлэв. | **Ж.Цэзэн** | 1. Тайланг үр дүнгийн даалгаварын шаардлагад нийцүүлсэн нэгдсэн төлөвлөгөөний дагуу бичиж боловсруулах;<br>2.Төслийн эцсийн үр дүн амжилттай хэрэгжихэд бусдаар гүйцэтгүүлэх ажлыг нарийвчлан тооцох, ажлын хөлсийг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | * Төслийн мониторингийн тайланг улирал бүр бичиж ШУТС-д цаасан болон цахим хэлбэрээр тайлагнав | | шаардлагатай хэсэг бүрт төлөвлөх шаардлагатай байв |
| | | Төслийн дэлгэрэнгүй тайланг 2 удаа, томилолтын тайланг 1 удаа бичиж ШУТС-д хүлээлгэж өгөв | | |
| | | Төслийн үр дүнгийн нэгдсэн тайланг боловсруулан бичиж ШУТС болон БСШУСЯ-ны захиалгат төслийн багт танилцуулах, засварлах, хүлээлгэн өгөх, төсөл дуусгах шат дараалсан ажлуудыг хийв | | |
| | | Төслийн санхүүгийн тайланг 2017, 2018 он тус бүрээр болон нэгдсэн тайланг боловсруулан гаргаж хэлэлцүүлэх, хүлээлгэн өгөх ажил | **Б.Ичинхорлоо**<br>**Э.Энхзул** | |
| **ДҮГНЭЛТ** | | * "ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЦАХИМ НЭГДСЭН НОМЫН САН" (2016-2018) Төслийг үр дүнгийн үндсэн 5 даалгавар, нэмэлт 2 ажлын бүтэцтэй, 10 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр амжилттай хийж дуусгав.<br><br>**Цаашид анхаарах зүйл:**<br>1. Монголын нийт номын сангууд нэгдсэн программ, нэг ангилалтай байх эрхзүйн орчин бүрдүүлэх, цуврал төслөөр цаашид бүх номын санг хамруулах;<br>2. "Монгол ном"-ын мэдээллийн нэгдсэн нөөцийг МУҮНС-д түшиглэн хуримтлуулах;<br>3. "Монгол ном"-ын мэдээллийг гадаадад солилцох, алслагдсан зайнаас хайх, унших цахим стандартыг боловсруулж хэрэгжүүлэх;<br>4. Ховор хуучин ном, баримтыг бүтэн бичвэрээр цахимжуулж хадгалж хамгаалах асуудлыг МУҮНС-ийн загвараар нийт номын сангуудад хэрэгжүүлэх;<br>5. Цахим программ хангамжийг хариуцах тусгай баг, байгууллага ажиллуулах | | |

## X. ТӨСЛИЙН АЖЛЫН ЭХЛЭЛ, ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭР

**2. Төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээ тогтоох, гэрээт ажилтны гэрээний заалт боловсруулж хэлэлцүүлэх**

Төсөлд хамрагдах сургуулиудыг өөрийнх нь хүсэлтээр сонгох, сонгосон сургуулийн номын сангийн цахим программд судалгаа хийх, бусад байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагтай гэж үзсэн тул:

Анхны уулзалт ярилцлагыг 2016.09.30—д ДБНС-ийн Консерциумын удирдлагатай уулзаж зөвлөлдөв. *(Хурлын тэмдэглэл №1-Хавсралтад үзнэ үү)* Уулзалтанд ирсэн төлөөлөгчид хөдөө орон нутгийн номын сангуудад "Mon biblio" цахим программ суулгах, засварлах ажилтай тул энэхүү дээд боловсролын цахим номын сангийн төсөлд оролцох боломжгүй гэсэн тул МУҮНС, МНСХ, БМИҮЗ зэрэг байгууллагын хамтын ажиллагаагаар төслийг цаашид үргэлжлүүлэн хийх шаардлагатайгэж үзээд МУҮНС дээр анхны уулзалт, хуралыг зохион байгуулан ажилласан билээ.

Уг хурлыг 2017 оны 03-р сарын 24-д МУҮНС-ийн захиралын өрөөнд хийж. *(Хурлын тэмдэглэл №2- Хавсралтад үзнэ үү)* "ДБЦННС" төслийг хэрэгжүүлэх эрх үүрэг, номын сангаас төсөрлд оролцогчдыг дэмжих, гэрээт ажилтны ажлын гэрээ байгуулах, санхүүжилтийн задаргаа, хувиарлалт хийх, сургалт явуулах талаар зөвлөлдөн ярилцаж төслийн анхны сургалтын Соёлын сургууль дээр хийх; Бат. Тунгалаг, Бат-Эрдэнэ, Баяртуяа нар сургуулиудаар явж сургалтын өмнө судалгаа хийх; төслийг дэмжсэн эрхзүйн орчин бүрдүүлэх /2016 оны 12-р сард ярилцаж тушаалын ноорог гарсан/ Үүний үр дүнд төслийн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин бүрдэж *(Хавсралт №3 МУҮНС-А/45 тоот тушаал, МНСХ-ны №1, БМИҮЗ-ийн №58 тоот)* төслийн үйл ажиллагаанд оролцогчдын нэрсийг баталгаажуулсан болно. Албан тоотыг их дээд сургуулийн захиралуудад явуулж төсөлд хамрагдах санал хүсэлтийг мэдэгдсэн нь төслийн ажлыг дэмжсэн, эрхзүйн орчинг бүрдүүлсэн ач холбогдолтой ажил болов.

СУИС-ийн Соёлын сургуулийн 107 тоотод "ДБСЦННС"-төслийн Сургалтыг яаралтай зохион байгуулах, захиалгат төслийг хэрэгжүүлэхэд гэрээт ажилтны ажил үүргийн хуваарь, төслийн багийн гишүүдийн үүрэг, хариуцлага, төсөлд хамтран ажиллах сонирхол зэргийг эцэслэн хэлэлцээд (Хурлын тэмдэглэл №3) дараах асуудлыг МУҮНС-ийн захирал, нягтланд танилцуулахаар болов. Үүнд:

1. Сургалт-I-ийн нэрийг "Дээд боловсролын эрдэм судлалд туслах цахим мэдээллийн сан" /ДБСЭСТЦМС" тогтож төслийг боловсруулах, илтгэн хэлэлцүүлэх, заах сэдвийг хянуулах зэрэг ажлыг зохион байгуулах;

2. Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа нарын сургуулиудаар явсан судалгаа болон сургалтанд оролцох номын сангуудын саналд үндэслэн төсөлд оролцох номын санг сонгох;

3. “Ажлын гэрээ”-ний заалтыг саналын дагуу засаж батлуулах зэрэг болно.

**Зураг №2: Соёлын сургуулийн 107 тоотод болсон хэлэлцүүлэг**





Хэлэлцүүлэг, хуралдааны үр дүнд гэрээт ажилтны гэрээний маягтыг эцэслэн боловсруулж МУҮНС захиралаар батлуулан, цалингийн олголтыг нягтлан бодогч Э.Энхзулын гарын үсгээр гаргаж үйл ажиллагааг явуулав.

Мөн 2017-04.14-д Ажлын гэрээг дахин боловсруулсан хийгээд сургалт явуулах талаар Соёлын сургууль дээр хэлэлцсэн асуудлыг МУҮНС-ийн захиралын өрөөнд дахин хэлэлцэж Сургалт-I-ийг зохион байгуулах зардлыг төслийн ЭШ-ний зардлаас яаралтай гаргуулах, сургалт хойшлуулахгүй байх; ҮНС-ийн захирал төслийн гэрээт ажилтны гэрээг батлах асуудлыг шийдвэрлэв. Харин ҮНС-д хадгалагдаж буй докторын диссертацийн ажлыг төслийн хүрээнд хийх саналыг энэ үед танилцуулснаар дараа дараагийн ажыг амжилттай шийдвэрлэсэн / энэ тухай хойно бичсэн/ билээ. *(Хурлын тэмдэглэл №4)*

**Зураг №1. МУҮНС-ийн захиралын өрөөнд хуралдсан**









## XI. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧНЫ СУДАЛГАА

**3. Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх орчны судалгаа, цахим программ хангамж, туршилт, ажиглалтын анхны судалгааг 2017 оны 03-р сарын 24-с хийж эхлэв.**

МУҮНС-д ашиглаж буй монгол хувилбартай “Коха” болон бусад их дээд сургуульд ашиглаж буй англи хувилбартай “Коха” программын давуу сул тал, ижил төстэй болон сайжруулах, өөрчлөх боломжийн талаар багийн гишүүд 2017 оны 03-р сарын 24, 27 –нд МУҮНС-ийн программ хангамжтай танилцаж ажиллав. Дээд боловсролын салбарт МУҮНС-ийн “Коха” программ нутагшуулах багийн ажилтан, бүртгэлийн номын санч Б.Бат-Эрдэнэ, номзүйч Г.Баяртуяа Сан хөмрөгийн хэлтсийн дарга **Бат.Тунгалаг** нараар ахлуулсан төслийн баг ажиллав.

Цахим программ дээр Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа нар, социологийн судалгаа авах, ажиглалт, дүгнэлт хийх ажилд Бат.Тунгалаг нар 2017 оны 04-р сарын 01-05-р сарын 31 хүртэл монгол улсын томоохон их дээд сургуулийн номын сангийн цахим программтай танилцаж судалгаа хийв. *(Хавсралт №5. Төслийн багийн анхны судалгааны баримт)*

Дээд боловсролын байгууллагуудын номын сангийн автоматжуулалт, цахим мэдээллийн сангийн өнөөгийн байдал, төсөлд хамрагдах боломжийг судлах зорилгоор 2017 оны 04 дугаар сарын 1-ээс 05 сарын 31 хооронд 22 их дээд сургуулийн номын сангуудад очиж судалгаа авч зөвлөгөө өгч ажиллав. *(Социологийн судалгаа №1)*

17 асуултын дагуу санал цуглуулж дүгнэж үзэхэд:

- Судалгаанд хамрагдсан номын сангуудын ихэнх нь Lib4U программ ашиглаж байна. Тус программын хөгжүүлэлтийг Wolves XXK болон тодорхой номын санчид хариуцан ажилладаг байна. Бэрхшээлтэй тал нь хуучин хувилбартай, хөгжүүлэлт болон нэмэлт ажил гүйцэтгүүлэх бүрт төлбөр шаарддаг гэж хариулсан.
- Серверийн хувьд бүх номын сангууд шаардлага хангахуйц байна.
- Электрон каталогжуулалтын хувьд нэгдсэн нэг стандарт баримталдаггүй, уламжлалт каталогжуулалтын мэдээллийг үндэслэн хийдэг нь ОУ-ын MARC-21 стандартын шаардлага хангахгүй байлаа. Энэ нь цаашид өөр хоорондоо мэдээлэл солилцох боломжгүй гэсэн үг юм.

- Программаас статистик тайлан мэдээ гаргаж авдагч тоон мэдээллүүдийн хувьд зөрүүтэй байдаг учир давхар уламжлалт бүртгэл хөтлөн хоёр ажил болдог нь харагдана.
- Судалгаанд хамрагдсан номын сангуудын нийт номын тоо нь 806.686 ширхэг, үүнээс сурах бичиг 336.694, диссетаци 1.141, магистрын ажил 10.070, бакалаврын дипломын ажил 3.598, эрдэм шинжилгээний бүтээл 12.696 байгаа нь тодорхой боллоо.

Дээрх судалгаанд үндэслэн: Эрдэм судлалд туслах цахим мэдээллийн санд хамрагдах байгууллага, номын санч, бүтээлийн тоог тодорхой гаргаж, бэлэн байгаа баазыг хөрвүүлэх талаар судлах, цаашид хийгдэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж үндсэн үйл ажиллагааг эхлүүлэх боломжтой гэж үзэж цаашдын ажлаа төлөвлөн ажлын явц, үр дүнгийн талаар шат дараалсан Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж ажиллав.

**СУРГАЛТ–I**

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САН

БМҮ ЗӨВЛӨЛ

## ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН
## “ЭРДЭМ СУДЛАЛД ТУСЛАХ ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН”

***/СУРГАЛТ-СУДАЛГАА/***

***2017 оны 04-р сарын 17***

**Сургалтын зорилго:** "Дээд боловсролын салбарын цахим нэгдсэн номын сангийн төсөл"-ийн тухай дэлгэрэнгүй мэдээлэх, төслийг хэрхэн хэрэгжүүлэх талаар санал солилцох, хамтран ажиллах, төсөлд хамрагдах сургуулийг сонгох.

2017 оны 04-17-нд **"Дээд боловсролын салбарын эрдэм судлалд туслах цахим мэдээллийн сан"** сэдэвт Сургалт-I-ийг зохион байгуулж, 35 сургууль, байгууллагын 60 гаруй номын санчдын дунд хэлэлцүүлэг санал авсны үндсэн дээр төсөлд хамрагдах хүсэлтийг 2017 оны 4 сарын 21-ны дотор албан тоотоор ирүүлж, сонгон шалгаруулахаар тогтов. Сургалтыг төслийн удирдагч Ж.Цэзэн, нарийн бичиг Ж.Тунгалаг нар хөтлөн СУИС-ийн СС-ийн 223 тоотод өглөөний 8:50-оройн 19:00 хүртэл үргэлжлүүлэн явуулж, төслийн багийн гишүүд доорх 9 сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Үүнд:

1. "Дээд боловсролын салбарын цахим нэгдсэн номын сангийн төсөл"-ийн танилцуулга
2. Олон улсын МАРС-21 стандартыг дэмжих "Коха" нэгдсэн цахим мэдээллийн сан
3. МУҮНС-д суурилсан "Коха" программын ашиглалт
4. Ном зүйн мэдээллийг цахимжуулахад тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх арга зам
5. Номын сангийн шинжлэх ухааны ангиллын дэлхийн чиг хандлага
6. Олон улсын ДЬЮгийн аравтын ангиллыг ашиглах арга зүй
7. Эрдэм судлалд туслах ном зүйн мэдээллийн сан бүрдүүлэх онол практик
8. Цахим номын сан зохиогчийн эрхийн асуудал, тэдгээрийн шийдэл
9. ДБСБ-ын магадлан итгэмжлэлд номын санд тавих шаардлага

Эдгээр илтгэлүүдийн хураангуй 68 хуудас сургалтын материалыг оролцогчдод хувилж, сертификат олгох, сургалтын багц /хавтас, үзэг, дэвтэр/ болгон бэлтгэж тараав. Мөн сургалтын хэлэлцүүлгийн баримтыг гарын авлага болгон эмхтгэж гаргав. Сургалтанд оролцсон хүмүүсээс социологийн судалгаа авсан ба сургалтанд хамрагдсан сургуулиудын төлөөлллүүд төслийн үйл ажиллагааг дэмжиж, ач холбогдлыг хүлээн зөвшөөрч хамтран оролцох хүсэлтэй байлаа. *(Социологийн судалгаа №2)*

**Зураг №3: Сургалт-I** **Илтгэгчид**














“Коха” программаас номын нэр, зохиогч, бусад мэдээллийг дэлгэрэнгүй хайхад нэгдсэн ангилал чухал бөгөөд гадаадын улс орнуудын ангиллын туршлагаас үзэхэд олон улсын ангиллыг баримтах нь зүйтэй гэж үзсэн тул судалгаа явуулах ажлыг Бат.Тунгалаг, Э.Оюунгэрэл, Ж.Цэзэн нар хариуцан ажиллав. Үүнд:

1.МУИС

2. ҮБХИС-зэрэг 2 томоохон номын сан ННА /ОХУ-ын/ ангилалтай байв.

Олон улсын нэгдсэн ангилалд бүрэн орох шаардлагатай талаар БСШУЯ-ны сайдын 2001 оны 06-р сарын 6-ны 180-р тушаал болон Номын санги йн холбооны албан тоотыг дахин хүргүүлэв. Төслийн явцад дээрх 2 сургууль олон улсын ангилалд нэгдэн орох ажлыг шуурхайлан явуулсны үр дүнд ҮБХИС 60 % ДАА-д орсон, МУИС ДАА ба ННА-ыг хавсран давхар ангилж байна. Бид олон улсын номын сангийн ангиллын үндсэн ботид тулгуурлан ном ангилах аргазүйн зөвлөмж гарын авлагуудыг боловсруулан гаргаж нийт номын сангуудад түгээн ашиглуулж байна.

**Зураг № 4: Олон улсын ангиллаар ном ангилах аргачлалын гарын авлага (№1,№2,№3)**

**Гарын авлага №1**




**Гарын авлага №2**



**Гарын авлага №3**




**Сургалтын илтгэлийн эмхтгэл: №4:**



Сургалтанд хамрагдсан их дээд сургуулиудаас өөрийн хүсэлтээр төсөлд хамрагдах санал ирүүлсэн сургуулийн нэрс:

**"Эрдэм судлалд туслах цахим мэдээллийн сан" төсөлд оролцохоор санал ирүүлсэн сургуулийн төлөв байдал**

| № | Сургууль | Хүсэлт ирүүлсэн | Ирүүлээгүй |
|---|---|---|---|
| 1 | АШУИС | 2017-04-19 | |
| 2 | Мандах бүртгэл дээд сургууль | 2017-04-19 | |
| 3 | МҮИС | 2017-04-20 | |
| 4 | ОУЭЗБДС | 2017-04-21 | |
| 5 | ОУ-ын Улаанбаатарын их сургууль | 2017-04-19 | |
| 6 | Отгонтэнгэр их сургууль | 2017-04-19 | |
| 7 | Сити их сургууль | 2017-04-19 | |
| 8 | СУИС | 2017-04-19 | |
| 9 | Соёлын сургууль | 2017-04-19 | |
| 10 | Технологийн дээд сургууль | 2017-04-19 | |
| 11 | Техник технологийн дээд сургууль | 2017-04-19 | |
| 12 | Улаанбаатарын их сургууль | 2017-04-19 | |
| 13 | Хангай дээд сургууль | 2017-04-19 | |
| 14 | ХИС-ийн харьяа Билиг дээд сургууль | 2017-04-19 | |
| 15 | ШинэАУДС | 2017-04-21 | |
| 16 | ЭЗШУИС | 2017-04-21 | |
| 17 | Этүгэн их сургууль | 2017-04-20 | |
| 18 | МУИС | | Албан тоот ирүүлээгүй |
| 19 | ҮБХИС | | Албан тоот ирүүлээгүй |
| 20 | ХААИС | | Албан тоот ирүүлээгүй |
| 21 | Хөгжим бүжгийн коллеж | | Албан тоот ирүүлээгүй |
| 22 | Цэцээ гүн дээд сургууль | | Албан тоот ирүүлээгүй |
| ДҮН | | 22 | |

Санал хүсэлт хүлээж авсан

Төслийн менежер Ж.Тунгалаг

Б.Бат-Эрдэнэ

Г.Баяртуяа

2017-04-19-нөөс 2017-04-21

**Сургалтын сертификат**

МОНГОЛЫН НОМЫН САНГИЙН "АРВАН УХААН" ХОЛБОО

# СЕРТИФИКАТ

Дугаар НС-НЗС-2017. № .......

......................................овогтой .......................................

**Монголын номын сангийн холбооноос зохион байгуулсан "ЭРДЭМ СУДЛАЛД ТУСЛАХ ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН" 2 багц цагийн сургалтанд суралцаж:**

- *Монгол улсын цахим нэгдсэн номын сангийн бүтэц, тогтолцоо*
- *Номын сангийн шинжлэх ухааны ангиллын дэлхийн чиг хандлага*
- *Монголын номын сангийн цахим программ-"Коха"*
- *Эрдэм судлалд туслах номзүйн мэдээллийн онол, аргазүй*
- *Номзүйн мэдээллийг цахимжуулах арга, туршлага зэрэг сэдвийг судалсан тул СЕРТИФИКАТ олгов.*

Монголын номын сангийн "АРВАН УХААН" холбоо

ТЭРГҮҮН Профессор (Sc.D) Ж.ЦЭЗЭН

Сургалтын менежер Дэд профессор Ж. Тунгалаг

*Улаанбаатар хот 2017*

Сургалтанд нийт 3,978,500 төгрөг төлөвлөснөөс 1,738,500 төгрөгийг МУҮНС-аас 2017 оны 04-р сарын 18-нд бэлнээр олгож зарцуулав. Сургалтын өмнө санхүүжилт орж ирээгүй учраас урьдчилсан захиалгаар бэлтгэл ажлыг хангаж төлөвлөсөн хугацаанд сургалтыг амжилттай зохион байгуулав.

**СУРГАЛТ-II: "Коха" программ ашигладаг Номын сангуудын инженер техникийн ажилтан, цахим каталогчдын уулзалт, хэлэлцүүлэг**

**Сургалт-II-ийн хүрээнд** 2017 оны 05-р сарын 19-нд Улаанбаатар хотын төв номын санг түшиглэн **Коха"** программ ашигладаг Номын сангуудын инженер техникийн ажилтан, цахим каталогчид илтгэл хэлэлцүүлэг хийж санал солилцон, "Коха" программын өнөөгийн төлөв байдал, цаашдын чиг хандлагын талаар хэлэлцэв.

**Зорилго:**

"Коха" программын ашиглалтын явцад тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж, туршлага солилцох" үүднээс коха программ ашигладаг номын сангуудын IT инженерүүдтэй уулзаж ярилцах, илтгэн хэлэлцүүлэх, зөвлөлдөж шийдэлд хүрэх.

МУҮНС-д ашиглаж буй монгол хувилбартай коха, их дээд сургуулиудад ашиглаж буй англи хувилбартай коха болон LIB4U программд орсон зарим баримтыг кохад хөрвүүлэхэд тулгарч байгаа бэрхшээл, өгөгдлийн зөрүү байдал зэргийг судалдсан мэргэжилтэн **Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа** нарын судалгааны явцад тулгуурлан энэхүү уулзалт, сургалтыг хийв (Хурлын тэмдэглэл, шийдвэр социологийн судалгаа-3-т тусгагдсан). Энд мөн МУҮНС-ийн сан хөмрөгийн хэлтсийн дарга Бат.Тунгалаг зохион байгуулагчаар хамтран оролцсон болно. Уг сургалтыг түшиглэн зохион байгуулж ажилласанд дараах сургуулийн мэргэжилтэн нар оролцов. Үүнд:

**Сургалт-II-ын сэдэв**




**Сургалт-II-д оролцогчид**

ОРОЛЦОГЧДЫН БҮРТГЭЛ

| № | Байгууллагын нэр | Овог нэр | Албан тушаал | Утас, хаяг | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|
| 1. | МУҮНС | Б.Тунгалаг | ФХХ-ийн дарга | | ✓ |
| 2. | МУҮНС | Б.Бат-Эрдэнэ | Номзүйч | | ✓ |
| 3. | МУҮНС | Г.Баяртуяа | Номзүйч | | ✓ |
| 4. | МУҮНС | Т.Наранзул | Инженер | | ✓ |
| 5. | МУҮНС | М.Ариунболд | Инженер | | ✓ |
| 6. | МУҮНС | Б.Сарандэлгэр | Арга зүйч | | ✓ |
| 7. | УБХНТНС | М.Отгонбаяр | МИТасгийн дарга | 99106822 | ✓ |
| 8. | УБХНТНС | О.Цог | Инженер | 91059699 | ✓ |
| 9. | УБХНТНС | Н.Одхүү | Каталогч | | ✓ |
| 10. | УБХНТНС | Ж.Мөнгөнзул | Системийн инженер | | ✓ |
| 11. | МНСК | Л.Гантулга | УЗД | | ✓ |
| 12. | МНСК | Т.Хайдав | УЗГ | | ✓ |
| 13. | МНСК | Ж.Баатарсүрэн | УЗГ, МУБИС | | ✓ |
| 14. | АШУҮИС-ийн Төв номын сан | З.Баярцэнгэл | Инженер | 91871199 | ✓ |
| 15. | МУИС-ийн Төв номын сан | Ч.Гансүх | Инженер | | ✓ |
| 16. | СУИС-ийн Төв номын сан | Бан.Тунгалаг | Эрхлэгч | 91992810 | ✓ |
| 17. | Соёлын сургуулийн номын сан | Г.Мандахбаяр | Инженер | 88202004 96607060 | ✓ |
| 18. | УИХ-ын Тамгын газрын номын сан | Б.Мөнхтөр | Инженер | | ✓ |
| 19. | ЧД-ийн Номын өргөө | Д.Нарантуяа | Номын санч | 88034132 | ✓ |
| 20. | Шинэ монгол технологийн ДС-ийн номын сан | С.Ганбаяр | Инженер | | ✓ |
| 21. | МНСХолбоо | Ж.Цэзэн | Тэргүүн | 99000159 | ✓ |
| 22. | Соёлын сургууль | Б.Дунал | Номын санч | | ✓ |
| | Нийт 38 хүн оролцов | | | | |

Бүртгэл хийсэн Б.Баят-Эрдэнэ

2017.05.19

## Сургалтын хөтөлбөр

БАТЛАВ: ТӨСЛИЙН УДИРДАГЧ Ж.ЦЭЗЭН

**"ДБСЭСТЦМС"-ТӨСЛИЙН ХҮРЭЭНД КОНА ПРОГРАММ ХЭРЭГЛЭГЧ НОМЫН САНГУУДЫН IT-ИНЖЕНЕРҮҮДИЙН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ СУРГАЛТ-УУЛЗАЛТ**

**Зорилго:** Koha программын ашиглалтын явцад тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж, туршлага солилцох

**Зохион байгуулагдах хугацаа**: 2017 оны 5 сарын 19-ний 10.00 цагт

**Зохион байгуулагч:** Монгол улсын Үндэсний номын сан, Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын Нийтийн төв номын сан, Монголын номын сангийн холбоо

**Оролцогч байгууллагууд**:

1. АШУҮИС-ийн Төв номын сан
2. МУИС-ийн Төв номын сан
3. СУИС-ийн Төв номын сан
4. Соёлын сургуулийн номын сан
5. УИХ-ын Тамгын газрын номын сан
6. ЧД-ийн Номын өргөө
7. Шинэ Монгол технологийн ДС-ийн номын сан

**ХӨТӨЛБӨР**

09.30-10.00 Оролцогчдын бүртгэл

10.00-10.03 Уулзалтын нээлт /ДБНСХ-ний тэргүүн, Профессор Ж.Цэзэн

УБХНТНС-гийн Маркетинг инновацийн тасгийн дарга н.Отгонбаяр/

10.03-10.25 УБХНТНС-гийн Коха программмын практик хэрэглээ, ярилцлага

10.25-10.45 МУИС-ийн номын сангийн практик хэрэглээ, ярилцлага

10.45-11.00 Кофе-брек

11.00-11.20 АШУҮИС-ийн номын сангийн практик хэрэглээ, ярилцлага

11.20-11.50 МУҮНС-гийн практик хэрэглээ, ярилцлага

11.50-12.00 Дүгнэлт. Социологийн судалгаа

13.00- Үдийн хоол

**Зохион байгуулагч:**

**Бат. Тунгалаг**

**Б.Бат-Эрдэнэ**

**Г.Баяртуяа**

2017.05.17

## Социологийн судалгаа №3

**Судалгаа-2. 2017-05-26**

**"Дээд боловсролын салбарын цахим нэгдсэн номын сан"-төслийн хүрээнд IT нараас авсан судалгааны дүгнэлт**

Koha программын ашиглалтын явцад тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж, туршлага солилцох зорилгоор зохион байгуулсан "КОХА программ хэрэглэгч номын сангуудын IT-инженерүүдийн туршлага солилцох уулзалт"-ын үеэр нийт 20 байгууллагын IT инженерүүд болон номын санчдаас судалгаа авлаа. Судалгааны үр дүнг нэгтгэвээс дараах үр дүн харагдаж байна. Үүнд:

1. Монголын номын сангууд 2010 оноос КОХА программыг нэвтрүүлж эхэлсэн байна.
2. Монгол болон англи хэлээр ашиглаж байна.
3. Программ дахь мэргэжлийн үг хэллэг өөр өөр ч цэгцэлж эхлэж байна.
4. Хуучин /L-soft, Alice, CDSISIS/ программаас 250.000 хүртэлх бичилт КОХА-д шилжүүлсэн
5. КОХА системийг номын санчдаас гадна мэргэжлийн инженерийн багаар хөгжүүлэлтийг хийлгэж байгаа нь сайшаалтай байна.
6. Коха системийн модулиудаас /Circulation, Patrons, Report өргөн ашиглаж байгаа бол Acquisitions, serials, authorits, offline circulation/ АУИС-аас бусад номын сангууд ашиглаж эхлээгүй байна
7. Коха системээр сан хөмрөгийн тооллого олонх нь явуулж үзээгүй байна.
8. Z39.50 ашиглан номын мэдээлэл татаж гаргахыг ихэнх номын сангууд ашиглаж чадахгүй байна.
9. Аль номын сангаас мэдээллээ татаж авахыг эрмэлздэг вэ? гэсэн асуултанд Үндэсний номын сангаас гэж 100 % хариулсан.
10. Цахим каталогжуулалтанд номын агуулгын гарчгийг оруулж байгаа хэд хэдэн номын сангууд байна.
11. Уншигч онлайнаар ном захиалдаг уу гэсэн асуултанд 100 % үгүй гэж хариулсан. МУҮНС-д ашиглаж буй КОХА системд энэхүү захиалгыг гүйцэтгэх боломжтой ч ашиглахгүй байгаа нь харагдлаа.
12. Цахим ном унших үйлчилгээг хэдхэн номын сан амжилттай нэвтрүүлсэн байна.
13. КОХА системээс ямар ямар тайлан мэдээг гаргаж авдаг талаарх асуултанд: өдөр тутмын бүртгэлийн мэдээ, олгосон номын ангиллын тайлан, номын нэр, тоо ширхэг, шинээр бүрдүүлсэн номын дагалдах баримт, каталогийн карт, баркод, формуляр, номын сан-хэрэглэгч бүрийн хийсэн үйлдэл зэргийг гаргах боломжтой гэж 100 % хариулсан.
14. Танай байгууллагын КОХА систем нь Нягтлан бодох бүртгэлийн программтайгаа холбогдсон эсэх гэсэн асуултанд 100 % үгүй гэж хариулжээ.
15. Санал хүсэлтээ бичих хэсэгт уулзалт амжилттай болсон, туршлага ч их солилцлоо, нэг нэгэнтэйгээ хамтран ажиллах хүсэл эрмэлзэлтэй болсон талаараа дурдаад энэхүү уулзалтаар коха систем анхлан нэвтрүүлэх гэж буй номын сангууд ч тодорхой мэдээлэл авлаа гэжээ.

**Нэгдсэн дүгнэлт:**

1. Коха системын ашиглалтад тулгарч буй томоохон бэрхшээлийн нэг нь ямар хугацаанд backup хийх ёстой, update-ийг өөрсдийн нэмсэн кодуудаа устгалгүйгээр хэрхэн хийж болох зэрэг нарийн мэдлэг мэдээллийн туршлага солилцсон уулзалт болсныг тэмдэглэж байна.
2. Мөн MARK 21-ийн талаарх мэдлэг мэдээлэл хомс, туршлага багатай байгаа тул энэ талын мэдлэг мэдээллийг хангаж өгөхийг энэхүү төслийн хүрээнд хамруулан өгөөсөй хэмээн хүссэн байна.
3. Дараа дараагийн сургалтыг системийн модуль тус бүрээр зохион байгуулвал үр өгөөж нь улам их юм гэсэн дүгнэлтэд хүрцгээсэн байна.

Судалгааг нэгтгэсэн: Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа

**Хавсралт тайлан бичсэн Төслийн удирдагч**

**..................................Ж.Цэзэн**

**2017-12-18**

ЭМШУҮИС, МУИС, СУИС, Соёлын сургууль, УИХ-ын Тамгын газрын номын сан г.м. төрийн болон хувийн хэвшлийн их дээд сургуулиудын номын сангийн төлөөлөгчид оролцож “УБ хотын Төв номын сан болон их дээд сургуулийн англи хувилбартай “Коха” программмын өнөөгийн байдал, практик хэрэглээ” –ний талаар хамтран хэлэлцэж, санал асуулга явуулсанд нийт оролцогчдын 80 % нь МУҮНС-ийн монгол хувилбартай кохаг нэвтрүүлэх, зарим өгөгдлийг сайжруулах, цаашид кохагийн бүх үзүүлэлтийг бүрэн монголчилж нутагшуулах олон талт ажил хүлээгдэж буйг тэмдэглэв. Нэгдсэн дүгнэлтэнд: “Коха” систем ашиглалтанд тулгарч байгаа томоохон бэрхшээлийн нэг бол ямар хугацаанд “backup” хийх, мөн update-ийг өөрсдийн нэмсэн кодуудаа устгахгүйгээр хэрхэн хийж болох зэрэг инженер, техникийн мэргэжлийн нарийн тохиргоо, мэдлэг, туршлага шаардах асуудлууд тулгарч байгааг тэмдэглэв. Цаашилбал, MARC-21 олон улсын стандартын талаарх мэдлэг, мэдээлэл хомс, манай номын санчид энэ талаар туршлага бага тул мэдээллийг улам өргөн дэлгэрүүлэх шаардлагатай, энэ удаад тун чухал мэдээллүүдийг авсан уулзалт боллоо гэж үзэцгээв. Инженер, электрон каталогчдын онцлон тэмдэглэсэн зүйл бол Коха программын модуль бүрээр цаашид сургалт явуулж, санал солилцох тун чухал гэж үзэв. Социологийн судалгаагаар “Коха” программыг ашиглахад тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд программыг бүрэн монголчилох, модуль бүрээр ярилцах шаардлагатай гэж үзсэн нь программын нарийн нийлмэл ойлголт Монголд төдий сайн боловсрогдоогүй, инженер техникийн нарийн мэргэжлийн ажилтан чухал шаардлагатай боллохыг, мөн цаашид шат дараалсан сургалтаар модуль бүрийн мэдлэг олгох шаардлагатай гэж үзсэнийг бид энэхүү төслөөр бүрэн гүйцэт шийдвэрлэж дуусгах боломжгүй, сайжруулах, боловсронгуй болгоход нийтийн хүч хөдөлмөр, бодлого, шийдвэрийн оролцоо үргэлжлэн хийгдэх ажил гэж үзлээ. Цаашид хэрхэн ажиллах, мөн төсөлд хамрагдах сургуулийн нэрсийг энэ сургалтаар бататган тогтоов.

## Төсөлд хамрагдах сургуулийн нэрс

"Эрдэм судлалд туслах цахим мэдээллийн сан" төсөлд
Оролцох сургуулийн нэрс

2017.05.19

| № | Сургууль | Хүсэлт ирүүлсэн |
|---|---|---|
| 1 | АШУИС | 2017-04-19 |
| 2 | Мандах бүртгэл дээд сургууль | 2017-04-19 |
| 3 | МҮИС | 2017-04-20 |
| 4 | ОУЭЗБДС | 2017-04-21 |
| 5 | ОУ-ын Улаанбаатарын их сургууль | 2017-04-19 |
| 6 | Отгонтэнгэр их сургууль | 2017-04-19 |
| 7 | Сити их сургууль | өгөөгүй |
| 8 | СУИС | 2017-04-19 |
| 9 | Соёлын сургууль | 2017-04-19 |
| 10 | Технологийн дээд сургууль | 2017-04-19 |
| 11 | Техник технологийн дээд сургууль | 2017-04-19 |
| 12 | Улаанбаатарын их сургууль | 2017-04-19 |
| 13 | Хангай дээд сургууль | 2017-04-19 |
| 14 | ХИС-ийн харьяа Билиг дээд сургууль | өгөөгүй |
| 15 | ШинэАУДС | 2017-04-21 |
| 16 | ЭЗШУИС | 2017-04-21 |
| 17 | Этүгэн их сургууль | 2017-04-20 |
| 18 | МУИС | 2017-05-19 |
| 19 | ҮБХИС | 2017-05-19 |
| 20 | ХААИС | 2017-05-19 |
| 21 | Хөгжим бүжгийн коллеж | 2017-05-19 |
| 22 | Цэцээ гүн дээд сургууль | 2017-05-19 |
|  | ДҮН | 20 |

Санал хүсэлт хүлээж авсан
Төслийн менежер Ж.Тунгалаг
Б.Бат-Эрдэнэ
Г.Баяртуяа
Бат.Тунгалаг

## Зураг №5: Сургалт-II-ын илтгэл хэлэлцүүлэг







**“ДБСЦННС” төслийн сургалтын материалыг цахимжуулах үйл ажиллагааны явц-I**

Төсөлд хамрагдсан 20 их дээд сургуулийн номын сангуудаар биечлэн явж сургалтын материалын цахимжсан байдалд судалгаа хийж хяналт тавих, хуучин LIB4U-д орсон баримтуудыг татаж хөрвүүлэх боломжийг судлахаар МУҮНС-ийн мэргэжилтэн Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа, Бат.Тунгалаг нар дотоодын 2018 оны 01-р сарын 1-ээс 10-р сарын 3 хүртэл 14 хоногийн хугацаатай ажиллав. Сургалт-II-р тогтсон 20 гаруй сургуулийн номын сангуудаар явж Үр дүнд:

1. Монгол ба англи хувилбартай Кохаг хэрэглэж буй номын сангуудын өгөгдлийн талбар олон янз, харилцан адилгүй байгааг Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа нар 2017.12.10 хүртэл судлав, цаашид сургалтын материалыг татаж Кохад хөрвүүлэх, МУҮНС-ийн мэдээ лэлд холбох ажлыг гадны байгууллагаар хийж гүйцэтгүүлэх шаардлагатай гэж тогтов.

2. БХИС, МУИС-ийн номын сан Оросын ангилалтай, бусад нь олон улсын ДАА-тай /сайдын 180-р тушаал/ байгааг Бат.Тунгалаг нар судалж, төсөлд хамрагдсан номын сангууд "ДАА"- дахь алдааг механик аргаар засах зөвлөмж өгч, БХИС-ННА-с ДАА руу шилжиж эхэлсэн. ДАА-аар ном ангилах цуврал 3 гарын авлага, зөвлөмж гаргах ажлын суурь тавигдав. Тус судалгааг 959,300 төгрөгөөр төсөвлөж 820,800 төгрөгийг зарцуулан ажилласан байна.

3. Судалгаагаар хийгдсэн дараагийн ажил бол дээд боловсролын салбарын номын сангийн сургалтын материалыг хуучин орсон цахим программаас авч Кохад хөрвүүлэх ажил байв. Уг ажлыг МУҮНС –ийн мэргэжилтэн Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа болон бусад инженер техникийн ажилтан дангаар хийх боломжгүй гэсэн дүгнэлтэнд хүрч тэдний хүсэлт, санаачлагаар гадны байгууллагаар хийж гүйцэтгүүлэх шийдвэр гарсан билээ. Иймд **"Коха"-**программыг МУИС-ийн хүрээнд болон бусад дээд сургуулийн номын сангуудад нэвтрүүлэн ашиглах талаар амжилттай ажилласан туршлагатай компьютерийн инженер багш Намсрайдорж овогтой Мөнхцэцэгтэй гэрээ байгуулах ажлыг МУҮНС-ийн "Коха"-хариуцсан мэргэжилтэн Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа нартай 2017.12-р сарын 1-нд 3 тоот гэрээг дам байгуулж ажиллав. /Сургалтын материал цахимжуулах ажил-II-д Н.Мөнхцэцэгээр гүйцэтгүүлсэн ажлыг үзнэ үү/

4. Бид төслийн явцад "МУҮНС төвтэй мэдээллийн нэгдсэн сан"-тай байж монголын нийт номын сангууд нэгдэн холбогдох, мэдээлэл солилцох боломжыг судалж цаашид анхааран ажиллах талаар чиг баримжаа болгож ажиллав. Юуны өмнө олон улсад "Коха" программыг хэрхэн ашигладаг талаар төгсөх курсын оюутан Т.Билэгбаяраар бакалаврын түвшинд судлуулан диплом бичүүлж ажиллав. Энэ нь нэгд, Коха программын ирээдүйг харах, Монголын нөхцөлд зөв сонголт болсон эсэх баримжааг авах; хоёрд, уг программд МУҮНС-ийн сан хөмрөг дэх Докторын диссертацийн мэдээллийг оруулж турших, Дээд боловсролын сургалтын материалыг хөрвүүлэхэд гарч болох бэрхшээлийг давхар шийдэх зорилготой байв. Төржаргалын Билэгбаярын "**Монгол улсын номын сан дахь "Коха" программ**" сэдвээр:

1. Монголын номын сангуудын "Коха" программын өнөөгийн байдал;
2. Гадаад улс орны "Коха" программын ашиглалтын тархац; зэргийг судалж гаргав.Үүний үндсэн дээр:

а/ Т.Билэгбаярыг 2018 оны 01-р сарын 1-с эхлэн төслийн гэрээт ажилтнаар авч, уг программ дээр МУҮНС- дахь докторын диссертацийг цахимжуулах ажлыг дагнан гүйцэтгүүлж амжилттай дуусгав.

б/ Олон улсад “Коха” программыг 1000 гаруй номын сан ашиглаж байгаа нь цаашид өсөх чиг хандлагатайг илрүүлж, Швед зэрэг улс “Коха” программыг дийлэнх номын сандаа сүлжээ болгон ашиглаж байгааг жишээ болгон авч, программын өгөгдлийг нарийвчлан судалсан;

в/ Коха программын талаар социологийн судалгаа авч Монголд дэлгэрүүлэх шаардлагатай гэж 90-с дээш %-ийн хариулт авсан зэрэг нь Монгол улсад энэхүү нээлттэй, үнэгүй программ одоогийн байдлаар бидний нөхцөлд шаардлага хангаж байна гэж үзсэн билээ.

**5. МУҮНС-ийн сан хөмрөг дахь 11, 577 Докторын диссертацийн баримтыг цахимжуулах ажлыг амжилттай хийж дуусгав**

XX-XXI зууны хооронд докторын зэрэг хамгаалсан монгол болон гадаадын судлаачдын докторын диссертацийн эх хувийн /зарим хураангуй/ талаарх номзүйн мэдээллийг МУҮНС-ийн монгол хувилбартай “Коха” программд оруулах нүсэр ажиллабар нь юуны өмнө Эрдэм судлалд туслах номзүйн мэдээллийн баазыг бүй болгох ажлыг үндэсний төдийгүй, дээд боловсролын салбарт загвар гаргаж турших, бусад номын сангуудад зөвлөмж бэлтгэх томоохон ажил байлаа.

Энэ талаар 2017 оны 11-р сарын 3-ны 13-14,30 хүртэл Соёлын сургуулийн 107 тоотод хуралдаж Номын сан судлалын төгсөх ангийн оюутан Т.Билэгбаярыг диссертаци цахимжуулах ажилд гэрээгээр авч ажиллуулах зэрэг бусад асуудлыг хэлэлцэв *(Хурлын тэмдэглэл №7).*

Бид энэ ажлыг **“Цахим диссертаци”** хэмээн нэрлэж, ажил дуусахад уншигч судлаач, үндэсний номын сангийн хамт олны өргөн талархлыг хүлээсэн билээ. Энэ нь Монголын дээд боловсролын салбарын төдийгүй, гадаад, дотоодын шинжлэх ухааны салбарын судлаачдад ихээхэн дөхөм ажлыг шийдэж өглөө. Мөн нөр их хөдөлмөр, нүсэр ажлыг оюутан, цахим каталогчид, инженерүүдийн тусламжтайгаар маш эрчимтэй, шахуу ажиллаж гүйцэтгэсэн болно. Энэ ажлыг цаашид МУҮНС-ийн удирдлага, мэргэжилтэн нар хариуцлагатай үргэлжлүүлэн явуулах шаардлагатайг тэмдэглэж байна.

Ийнхүү XX зууны дунд үеэс одоог хүртэл МУҮНС-д хадгалагдаж буй **11.577** ширхэг докторын диссертацийн нэг бүрчилсэн мэдээллийг цахимжуулж, дэлгэрэнгүй тайланг бичиж, БСШУСЯ, ШУТС-ийн холбогдох мэргэжилтэн, МУҮНС-ийн удирдлагыг байлцуулж 2018 оны 12-р сарын 18-д МУҮНС-д хүлээлгэн өглөө.

МУҮНС-ийн сан дахь Докторын диссертацийг нэр төрөл, тоо хэмжээ, монгол болон гадаад хэлээрх байдал, диссертаци бичиж хамгаалсан цаг хугацаа, боловсролын ба шинжлэх ухааны докторын нэр төрөл зэргээр судалж үзвэл дараах тоо баримт харагдаж байна:

**Хүснэгт №1: МУҮНС-ийн сан хөмрөг дахь докторын диссертацийн цахим мэдээллийн**

**1. МУҮНС дахь Докторын диссертацийн үсэг дараалал**

| **Үсэг дараала** | **Диссер та-** | **Хураа нгүй** | **Нэгдсэн тоо** |
|---|---|---|---|
| **А** | 278 | 126 | 404 |
| **Б** | 924 | 714 | 1638 |
| **В** | 30 | 18 | 48 |
| **Г** | 334 | 243 | 577 |
| **Д** | 531 | 369 | 900 |
| **Е** | 6 | 15 | 21 |
| **Ё** | 11 | 5 | 16 |
| **Ж** | 169 | 100 | 269 |
| **З** | 56 | 42 | 98 |
| **И** | 31 | 18 | 49 |
| **К** | 28 | 24 | 52 |
| **Л** | 179 | 83 | 262 |
| **М** | 258 | 198 | 456 |
| **Н** | 315 | 250 | 565 |
| **О** | 285 | 240 | 525 |
| **Ө** | 65 | 55 | 120 |
| **П** | 111 | 69 | 180 |
| **Р** | 40 | 55 | 95 |
| **С** | 360 | 247 | 607 |

**2. МУҮНС дахь Докторын диссертацийн нэр төрөл, тоон үзүүлэлт:**

| **№** | **Нэр төрөл** | **Too ширхэг** | **Хэл, эзлэх хувь** | | |
|---|---|---|---|---|---|
| | | | **Монго** | **Орос** | **Бусад** |
| 0 | Ерөнхий анги | 546 | 50% | 40% | 10% |
| 1 | Философи ба сэтгэлзүй | 1068 | | | |
| 2 | Шашин | 320 | | | |
| 3 | Нийгмийн ухаан | 1658 | | | |
| 4 | Хэл | 1656 | | | |
| 5 | Байгалийн шинжлэх ухаан ба математик | 1678 | | | |
| 6 | Технологи (Хавсрага шинжлэх ухаан) | 1405 | | | |
| 7 | Урлаг, дүрслэх ба чимэглэх урлаг, түүнд хамаарах сэдэв | 369 | | | |
| 8 | Уран зохиол ба уран илтгэхүй | 958 | | | |
| 9 | Түүх, газарзүй | 1919 | | | |
| | **Дүн** | **11577** | | | |

**МУҮНС дахь Докторын диссертацийн гаралтын мэдээний судалгаа**

| № | Гаралтын мэдээ | Too ширхэг | Хэл, эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Монгол | орос | Бусад |
| 1 | 1950 он хүртэл | 1 | - | орос | - |
| 2 | 1950-1960 | 161 | 1% | 99% | - |
| 3 | 1961-1970 | 696 | 2% | 97% | 1% |
| 4 | 1971-1980 | 2596 | 30% | 50% | 20% |

| | | | |
|---|---|---|---|
| **Т** | 445 | 290 | 735 |
| **У** | 84 | 49 | 133 |
| **Ү** | 42 | 25 | 67 |
| **Ф** | 1 | 3 | 4 |
| **Х** | 214 | 94 | 308 |
| **Ц** | 672 | 196 | 868 |
| **Ч** | 553 | 212 | 765 |
| **Ш** | 375 | 143 | 518 |
| **Ы** | 1 | 2 | 3 |
| **Э** | 789 | 425 | 1214 |
| **Ю** | 11 | 16 | 27 |
| **Я** | 21 | 32 | 53 |
| **ДҮН** | **7219** | **4355** | **11.577** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | 1981-1990 | 1973 | 30% | 50% | 20% |
| 6 | 1991-2000 | 1885 | 50% | 40% | 10% |
| 7 | 2001-2010 | 2416 | 60% | 30% | 10% |
| 8 | 2011-2019 | 1849 | 85 % | 10% | 5 % |
| | **Дүн** | **11577** | **36,8** | **50,3** | **12,9** |

**МУҮНС дахь Шинжлэх ухааны докторын (Sc.D) диссертацийн нэр төрөл, тоо**

| **№** | **Нэр төрөл** | **Тоо ширхэг** | **Хэл, эзлэх хувь** | | |
|---|---|---|---|---|---|
| | | | **монгол** | **орос** | **бусад** |
| 0 | Ерөнхий анги | | | | |
| 1 | Философи ба сэтгэлзүй | 23 | 10 | 12 | 1 |
| 2 | Шашин | | | | |
| 3 | Нийгмийн ухаан | 95 | 45 | 43 | 7 |
| 4 | Хэл | 59 | 43 | 13 | 3 |
| 5 | Байгалийн шинжлэх ухаан ба математик | 105 | 17 | 68 | 20 |
| 6 | Технологи (Хавсрага шинжлэх ухаан) | 31 | 8 | 18 | 5 |
| | Анагаах Ухаан-610 | 65 | 22 | 41 | 2 |
| | Хөдөө аж ахуй-630 | 57 | 23 | 30 | 4 |
| 7 | Урлаг, дүрслэх ба чимэглэх урлаг | 4 | 3 | 1 | - |
| 8 | Уран зохиол ба уран илтгэхүй | | | | |
| 9 | Түүх, газарзүй ба | 52 | 25 | 27 | - |
| **ДҮН** | | **491** | **196** | **253** | **42** |

**МУҮНС-ийн сан дахь Докторын диссертацийг цахимжуулах ажлын явц**

МУҮНС-ийн монгол хувилбартай Кохад 11,577 нэрийн диссертацийн баримтыг оруулснаар бусад дээд боловсролын байгууллагын сургалт-судалгааны баримтын мэдээллийн сантай нийт =28,686 нэгж баримтын **“Эрдэм судлал”** нэртэй мэдээллийн сантай боллоо.

Улмаар 2018 оны 12-р сарын 18-нд “Цахим диссертаци”-ийг тусгай хөтөлбөр, арга хэмжээний дагуу МУҮНС-д хүлээлгэн өгөх үйл ажиллагаа болов. Диссертаци хүлээлгэж өгөх ажлыг 807,980 төгрөгөөр төсөвлөж, төслийн захиалагч байгууллагын төлөөлөгчдийг урин оролцуулав.

**Зураг №6: МУҮНС дахь докторын диссертацийг цахимжуулах ажлын явц**





**Урилага, хөтөлбөр**




**Цахим диссертаци-гарын авлага-№5**



**Зураг № 7: МУҮНС-ийн "Цахим диссертаци"-ийг хүлээлгэн өгөх арга хэмжээ**

**"Дээд боловсролын цахим нэгдсэн номын сан" төслийн хүрээнд хийгдсэн МУҮНС-д хадгалагдаж буй докторын диссертацийг цахимжуулах ажлыг хүлээлгэн өгөх арга хэмжээний хөтөлбөр**

**Хаана:** МУҮНС-ийн захирлын албан тасалгаанд
**Хэзээ:** 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдөр 11:00-13:00 цагт

| № | Үйл ажиллагааны нэр | Хариуцах эзэн | Хугацаа |
|---|---|---|---|
| 1 | "Цахим диссертаци"-ийн фондтой танилцах | **Б.Тунгалаг** МУҮНС-ийн фондын хэлтсийн дарга Соёл судлалын (Ph.D) доктор | 11.00 -11.20 |
| 2 | Нээлтийн үг | **Б.Ичинхорлоо** МУҮНС-ийн захирал, төслийг гүйцэтгэх байгууллагын дарга | 11.20-11.30 |
| 3. | Төслийн удирдагч | **Ж.Цээн** МНСХолбооны тэргүүн Хэлбичгийн шинжлэх ухааны (Sc.D) доктор, профессор | 11.30-11.40 |
| 4. | "МУҮНС дахь цахим Диссертац"-ийн танилцуулга | **Т.Билэгбаяр** Диссертацийг цахимд оруулсан номын санч **Ч. Гансүх** МУҮНС-ийн Диссертацийн фондын номын санч | 11.40-12.00 |
| 5. | БСШУСЯ | **Г. Оюунцэцэг** ШУТБГ Улсын захиалгат төсөл, салбарын байгууллагын хөгжлийн бодлого хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн | 12:00-12:10 |
| 5. | ШУТС-ийн захирал | **Д.Энхжаргал** ШУТС-ийн захирал, Химийн ухааны доктор | 12.10-12.20 |
| 6 | Санал сэтгэгдэл ШУТС-ийн төлөөлөл | **Б. Оттонжаргал** ШУТС-ийн санхүү хэлтсийн дарга **Д. Наранцацралт** ШУТС-ийн мэдээллийн тэнхмийн ахлах мэргэжилтэн **Л.Батдэлгэр** ШУТС-ийн Улсын захиалгат төсөл хариуцсан шинжээч, Бусад гишүүд | 12.20-12.30 |
| 7 | Үдийн зоог | Үйл ажиллагаанд оролцсон 20 хүн | 12.30-13.00 |

**Цахим диссертаци хүлээлгэн өгөх үйл ажиллагаа**
**зохион байгуулагч:** Б.Тунгалаг **Бат. Тунгалаг**

1







HITACHI




EXIT


EXIT

## Гадаад улс орны туршлага судлах ажил

Төслийн ажлаар гүйцэтгэх бас нэг томоохон ажил бол гадаад улс орны дээд боловсролын салбарын номын сангуудын туршлагыг судлах явдал байлаа. Төслийн удирдагч Ж.Цэзэн миний бие 2018 оны 2-р сарын 11-24 хүртэл ХБНГУ-ын Төв номын сан, Гунбольдийн их сургууль ба Гёттингин их сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судлахаар явж ирлээ. Дараах үйл ажиллагаатай танилцаж судлав. Үүнд:

### 1. ХБНГУ-ын Гунбольдийн их сургуулийн номын сангийн үйл ажиллагаа

**Зураг № 8: Гунбольдын их сургуулийн Ази, Африкийн судлалын салбар**




Берлиний Гунбольдийн их сургуулийн Ази Африкийн сургуульд Монгол, төвд, турк, бусад Ази Африкийн судлалыг явуулдаг. Тус сургууль нь 1810 онд Александр, Вильхелм фон Хумболдтын санаачилгаар байгуулагдсан. 1945 оноос хойш их сургууль нь Зүүн Европын эрдэм шинжилгээний төвүүдийн нэг болсон, одоогийн байдлаар 35,000 оюутан суралцаж байна. Ази, Африкийн одоогийн салбар нь 1887 онд Дорно дахины хэл семинар (СОС) нэртэй байгуулагдаж, 1945 оноос өнөөгийн Ази, Африкийн судлал нь янз бүрийн судалгааны чиглэлээр хамтран ажиллах болжээ. 1968 онд Ази судлалын хэсгийг Гунбольдийн их сургуульдаа байгуулж, 2005 оноос Ази, Африкийн судалгааны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Ази, Африкрикийн салбарт Монгол хийгээд бусад орноос монгол судлалаар олон оюутан бакалавр, магистр, докторантад суралцаж, жил бүр Монгол оронд ирж дадлага, хээрийн судалгаа хийдэг, мөн ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн тэтгэлэгт герман оюутнууд суралцаж, монголоор ярилцаж, бичиж, судалж байна. Берлин хот-ын төвдөө уг салбар байршилтай.

**Зураг №9. Гунбольдын их сургуулийн төв номын сан ба Уншлагын заал**





**Зураг №10. Цахим хайлтын каталоги**



**Зураг №11. Эрдэм шинжилгээний тэнхмийн чөлөөт үйлчилгээний фонд**



**Дүгнэлт:** Бакалаврын сургалтын номын сангаас Эрдэм шинжилгээний номын сангийн үйл ажиллагааг тусад нь тэргүүлэх чиглэл болгож үздэг. Тухайлбал Гунбольдийн их сургуулийн Ази Африк судлалын тусгай номын сантай, монгол номыг жил бүр тусгай санхүүжилтээр бүрдүүлдэг. Чөлөөт уншлагын тэнхимд тасралтгүй уншлага, судалгаа хийгддэг. ДАА-д суурилсан өөрийн дансны дугаарын ангилалтай. Цахим өгөдлийг тусгай компаны, байгууллага хариуцдаг. Кохатай төстэй олон үзүүлэлт бүхий өгөгдөлтэй. Төв номын санд монгол гар бичмэл барын номын тусгай фондтой, 12 евроны үнэтэй цахим карт нээлгэж тусгай хүн дагалдуулан үзүүлдэг. Нарийн хяналттай, хадгалалт хамгаалалт их сайн.

**2. ХБНГУ-ын төв номын сан /Зураг №12/**






Берлин хотын улсын төв номын санг үзэж танилцав. Хоёр Герман нэгдсэний дараа Марбург хотод хадгалагдаж байсан Монгол гар бичмэл номуудыг Төв номын санд авч ирсэн бодит байдлыг миний бие олзуурхан үзэж Монгол ном судлаачдад чухал мэдээлэл болохыг дашрамд товч тэмдэглэж байна.

**Зураг №13. Монгол гар бичмэл ба төвд Ганжуурын нүүр хуудас**





1705 онд бичсэн Монгол гар бичмэл Ганжуурын 226 боть байна. Түүнийг 1892 онд хүн гараас худалдаж авсан байна. Арын хуудас нь 4 бурханы дүрстэй, 544-р дугаартай, энэ нь Хайссигийн каталогийн дугаартай давхцана. Мөн 1775 онд Бээжинд төвдөөр бичсэн гар бичмэл Ганжуур хадгалагдаж байна. Энэтхэгт дэвтэрчилж хэвлэсэн Монгол Ганжуурын төвд барын эх /Монгол барын Ганжуурын 225 боть, /1979/ байна. Нэг боть нь 700 гаруй хуудастай, 100-аад боть бүтээл юм.

**3. ХБНГУ-ын Гөттингин их сургуулийн бакалаврын номын сан* /Зураг № 14/**






**ХБНГУ-ын Гөттингин их сургуулийн номын санг Герман улсын "Цахим мэдээллийн төв" гэж үздэг**. Эртнээс нааш эрдэм шинжилгээний уншлагыг голлож ирсэн, судалгаа шинжилгээний бүтээл арвинтай, одоогоор 8 сая нэгж баримттай. Социализмын үед Европын улс орнуудаас докторын түвшний судалгаа хийгчид тусгай зөвшөөрлөөр ирж удаан хугацаанд ном уншиж судалдаг судалгааны төв байсан.

Тус номын санд  их сургуулийн дэргэдэх, Доод Саксоны харъяа Шинжлэх ухааны академийн номын сан хамаардаг. Энэхүү Шинжлэх ухааны академийн номын сан нь Германы шинжлэх ухааны томоохон номын санд орох бөгөөд дэлхийн олон орны номын сангийн хамтарсан төслүүдийг хэрэгжүүлж, олон орны судлаачдад үйлчилгээ үзүүлдэг. 2002 онд Германы шилдэг номын сан болсон. Захирал нь Вольфрам Хорстманн. Шинээр байгуулагдсан 6 салбартай, харин хотын төвд байрлах хуучин салбарт гар бичмэл, ховор ном, газрын зураг шинжлэх ухааны түүхэн баримт бүхий хадгаламжтай. 2016 оны байдлаар  8 сая нэгж баримтаас 14,000 гар бичмэл,  3100 эртний ном г.м. бусад баримт хадгалагддаг. 2004 оноос  судалгааны дэд бүтцийг буй болгож, нээлттэй үйлчилгээг хэрэгжүүлсэн. "Герман улсын судалгааны фонд" **(DFG)**-оос "Мэргэжлийн мэдээллийн үйлчилгээ" хөтөлбөр хэрэгжүүлдэг. Тухайлбал, "Номын сан", "Математик", "Физик" г.м нарийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг.

* Niedersachsen state-und universitÄtsbibliotek Göttingen

Гөттингийн их сургуулийн номын сан нь Берлин улсын төвлөрсөн номын сан болон улсын хэмжээний бүхий л номын сангийн сүлжээ хариуцсан байгууллагатай **(ГН)** хамтран улсын хэмжээний “Электрон нөөц”-ийг бий болгох тусгай зөвшөөрөлтэй ажилладаг төв нь юм. 2014 оноос их сургуулийн тооцоолон бодох  төв **(GWDG)** тэй хамтран Герман дахь шинжлэх ухааны судалгааны дэд бүтцийг хөгжүүлэх “**DARIAH-DE**” төсөл хэрэгжүүлж байна. Европ болон дэлхий нийтэд нээлттэй судалгааны дэд бүтцийг (Open AIRE 2020, COAR) хамтран байгуулахад дэмжлэг үзүүлдэг. Энэ мэт Гөттингийн их сургуулийн номын сан нь судалгаа шинжилгээ хийдэг  эрдэмтэн, судлаач нарт XYIII зуунаас нааш үйлчилж эхэлсэн бөгөөд өдгөө дэлхий дахинд нээлттэй үйлчилгээ үзүүлэх электрон судалгааны төв болж байгаагаараа бидний сонирхлыг ихэд татсан юм. Цаашид Монголын талаас аль ч салбарын эрдэм судлалын цахим хайлтын системээр хамтран ажиллах бүрэн боломжтой газар юм.

**Зураг №15. Фонд, уншлага**



**Зураг № 16. Цахим хайлт**









**3а.Гөттингин их сургуулийн дэргэдэг Георг Августийн их сургуулийн эрдэм шинжилгээний номын сан /Зураг №17/**




Орчин үеийн цахимжуулсан мэдээллийн сангийн талаар Герман улсад толгойлох байгууллагуудтай хамтран эрдэм шинжилгээг дагнан дэмждэг төвлөрсөн номын сан юм.

**Цаасан ба цахим каталоги:**

Гөттингин их сургуулийн номын сан нь төрөл анги, зүйлчилсэн, он дарааллын г.м. олон төрлийн цаасан каталогийг өргөн ашигладаг. Төрөл зүйл дотор дансны дугаарыг голлон зааж байрлуулсан. Монгол улс 2000 он гарсаар уламжлалт каталогоос гарч бүх зүйлээ цахимжуулах зорилго тавьж ажиллаж байгаа юм. Гэвч гадаад орны туршлагаас үзэхэд хуучин цаасан каталогийг орхиогүй, харин ч үргэжллүүлэн хөтөлсөөр байна. Бидний цахимжуулах аргаас өөр, аль болох цаасан каталоги, номзүйн бүртгэл мэдээллээ улам боловсронгуй болгох, хадгалах бодлого баримталж буй нь харагдлаа.

**Зураг№18:Төрөл анги, зүйлчилсэн, он дарааллын каталоги**



Мөн энэ номын сан нь хуучин бүртгэл дансаа ширэн хавтастай болгож хадгалсан нь XYIII зуунаас нааших зүйлийг хамарсан 1172 дэвтэрлэж үдсэн баримт бий.

**Зураг№19:Дэвтэрчилсэн каталоги**



**Зураг№20: Цахим каталоги**




**Зураг№21: Уншлагын тусгай өрөө**



Номын сангийн давхар бүрт цахим техник хэрэгсэл байрлуулсан, уншигч өөрснөө ажиллуулж ашигладаг. Энэ нь ном баримтаас хуулж олшруулах, татаж ашиглахыг зөвшөөрсөн гэсэн үг. Цахим каталогоос хайлт хийх арга **Кохатай** ижил. Гэхдээ цахимжуулах ажил номын санчдад хамааралгүй, тусгай инженерүүд бүхий баг, компани хариуцдаг. Электрон хайлтаас хайж үзэхэд 10 гаруй монгол ном төрөл зүйлээр орсон. Хятад эх сурвалж хязгааргүй их байв.Соронзон хаалга нь монголын номын сангийнхаас өргөн, энгийн хаалганаас тусгай хаалганд суулгасан. Уншлагын тусгай кабин, өрөө тасалгаатай. Нэг давхартай 20 гаруй уншлагын тусгай тоног төхөөрөмж бүхий кабинтай. Дотор нь уншиж байгаад орхисон ном баримт, цүнх сав байна. Дараа өдөр нь үргэлжлүүлэн суудаг.

**3б. Георг Августийн их сургуулийн Аашийн угсаатны музей дахь монгол гар бичмэл ном /Зураг №22/**




Гөттингийн их сургуулийн угсаатны цуглуулга Герман хэлээрх судалгааны чухал эх хэрэглэгдэхүүн болдгоороо дэлхийд дээгүүр ордог. Эдгээр цуглуулга **Георг Томас фон Аш (1729-1807)** -ийн XYIII зууны 2-р хагасаас эхэлж бүрдүүлсэн зүйлд тулгуурласан. Тэр Санкт-Петербургд төрсөн, улмаар 1744 онд Гөттингенд судалгаа хийхээр ирсэн. 1750 онд Георг Августын их сургуульд докторын зэрэг хамгаалж, орос орондоо буцсан хэдий ч тэрээр Гөттингийн их сургуульд 1771-1806 онд 120 гаруй бэлэг дурсгалын зүйлийг илгээж байжээ. Орчин үед 17,000 нэгж объектээр тоологддог . Энд зураг, газрын зураг, гэрэл зураг, түүний дундад азиар явсан гар бичмэл тэмдэглэл, монгол бичгээр тэмдэглэсэн судар, товхимол зэрэг бусад эд өлгийн зүйлүүд орно. 2017 онд “Georg-August-Universitдt Gцttingen” онлайн хэлбэрт бүх баримтуудын мэдээлэл бүрэн орж ашиглагдсан.

**Тэнд Монгол гар бичмэл судар, тэмдэглэл хадгалагдаж байна /Зураг №23/**








Эдгээр монгол гар бичмэлийг цахимаар хуулах, олшруулах фото хальсанд буулган авахыг бүрэн зөвшөөрч байв. Учир нь цахимжсан тул судалгааны эргэлтэнд оруулах нь зөв гэж үзсэн байдаг. Энд буй цуглуулгаын талаар томоохон хэмжээний каталогийг хийж гаргасан байна. Үндсэндээ баруун европод өдгөө монголд байхгүй ховор хуучин судар номыг цуглуулж зүй зохистой хадгалж хамгаалах талаар улсаас томоохон арга хэмжээ авдаг, тусгай хамгаалалттай. Энд монгол судлаачид тасралтгүй ирж судалгаа шинжилгээ хийдэг. Бид энэ мэт гадаад дотоодын коха программ ашиглалтын судалгаа, туршлага судалсны үр дүнд “Олон улсын

MARC-21 форматыг дэмжигч “Коха” программын ашиглалт”- нь олон улсад ашиглагдаж буй нээлттэй программ бөгөөд дэлхийн ихэнх улс орны номын сангууд өөр өөрийн хэрэгцээнд тохируулан сайжруулан боловсруулж ашигладаг болох талаар гарын авлага боловсруулж төслийн болон бусад номын сангуудад тарааж ажиллав.

**Гарын авлага-№6**




**Дүгнэлт:** Германы сургалт-судалгааны томоохон төв болох Гөттингин болон Гунбольдын их сургуулийн номын сангийн цахим хөгжил дараах шинжтэй:

1. Номын сангийн өдөр тутмын үйл ажиллагааг ээлжээр хийж гүйцэтгэдэг үйлчилгээний тусгай салбартай

2. Номын сангийн мэдээлэл хайхад зориулсан Цахим программыг тусгай инженерийн алба, компани улсын ба сургуулийн хэмжээнд хариуцдаг.

3. Цахим хайлтын систем “Коха” программтай ижил, дотроо нарийвчилсан

4. Цаасан каталогийг чухалчилж үздэг, үргэлжлүүлэн хийж ашигладаг байна.

5. Эртний бүх бүртгэл, каталогийг дэвтэрчилэн үдэж хадгалдаг тусгай тэнхим, хариуцагч номзүйчтэй

6. Нэг улс орны төдийгүй, олон улсын хооронд тодорхой сэдэв зүйл, салбар шинжлэх ухааны талаарх мэдээллийг мэргэжлийн номзүйчид, мэдээллийн ажилтан хийдэг

7. Номзүйн мэдээллийг цахимд оруулах ажлыг тусгай төлөвлөгөөт ажлаар улс даяар нэг стандартаар хийгддэг.

## 9.“ДБСЦННС” төслийн сургалтын материалыг цахимжуулах үйл ажиллагааны явц-II

“ДБСЦННС” төслийн ажил үргэлжлэн явагдаж Б.Бат-Эрдэний баг 2018 оны 10-р сарын 1-ээс 12-р сарын 31 хүртэл дараагийн шатны ажлыг дараах төлөвлөгөө гарган ажиллаа.

БАТЛАВ

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ ҮНС-ГИЙН ЗАХИРАЛ Б.ИЧИНХОРЛОО

ПРОГРАММААС КОХА СИСТЕМД ОРУУЛАХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2017-11-16-ны өдөр

| № | Номын сангийн нэр | Их дээд сургуулийн хаяг | Хариуцах хүний нэр, утас | Хийх ажил | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хөрвүүлэлт болон импортлох хугацаа | Нэгдсэн санд холбогдох хугацаа | Гүйцэтгэх ажилтан |
| 1 | АШУҮИС-ийн номын сан | УБ, СБД, Чойдогийн гудамж-3, УБ-46, ш/х-111 | Эрхлэгч Э.Оюунгэрэл-99035782 | 2017.12.04-19 | 2018 оны 1-2-р сар | Б.Бат-Эрдэнэ |
| 2 | СУИС-ийн Төв номын сан | 210646, УБ, СБД, Бага тойруу-26. | Эрхлэгч: Тунгалаг 91992810 | | | Г.Баяртуяа |
| 3 | МУИС-ийн Төв номын | 210646, УБ, СБД, Бага тойруу, Их сургуулийн гудамж-1. ш/х-337. | Захирал Цэрэн: 99035971 | | | Б.Бат-Эрдэнэ |
| 4 | Соёлын дээдийн номын сан | ЧД, Бага тойруу-26, УБ 210646 | Эрхлэгч Дунал 11325205 | | | Г.Баяртуяа |
| 5 | УБИС-ийн номын сан /захын хажууд/ | УБ, БЗД, 5-р хороо, 13-р хороолол, Намнянжугийн гудамж /төв байр/. | Эрхлэгч: Оюунбилэг 99161700 | 2017.12.04-12 | 2018 оны 3-4-р сар | Б.Бат-Эрдэнэ |
| 6 | Мандах бүртгэл дээд сургуулийн номын сан | УБ, СХД, 18-р хороо, Үйлдвэрчний эвлэлийн гудамж. УБ-37, ш/х-441 | Эрхлэгч: Гомбожаргал-99784970 | | | Г.Баяртуяа |
| 7 | ОУ-ын УБИС-ийн номын сан /Дүүрэгт/ | БЗД, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө | Эрхлэгч: Оюунцэцэг 11453567 | | | Б.Бат-Эрдэнэ |
| 8 | БХИС-ийн Төв номын сан | 210622, УБ, БЗД, 16-р хороо, Улаанхуаран, МУ-ын баатар Д.Нянтайсүрэнгийн гудамж. | Эрхлэгч: Мягмарсүрэн 88118665 | | | Г.Баяртуяа |
| 9 | ОУЭЗБДС-ийн номын сан | УБ, БГД, 20-р хороо, Гуравжингийн гүүр. | Эрхлэгч: Цэндсүрэн-88058531 | | | Б.Бат-Эрдэнэ |
| 10 | ЭЗШУИС-ийн номын сан МОНОС | УБ, СХД, Сонсголонгийн тойруу-20. УБ-37, ш/х-62 | Эрхлэгч: Түмэннаст-95221166 | 2017.12.14-20 | 2018 оны 5-6-р сар | Г.Баяртуяа |
| 11 | МҮИС-ийн номын сан | БГД, 11-р хороо, баруун тасган, Энигма төв | эрхлэгч: Энхжаргал-99141102 | | | Б.Бат-Эрдэнэ |
| 12 | Этүгэн их сургуулийн номын сан | УБ, СБД, 8-р хороо, Бээжингийн гудамж-29. УБ-46А, ш/х-109 | Эрхлэгч: Болор-99160632 | | | Г.Баяртуяа |
| 14 | Хангай дээд сургуулийн номын сан | УБ, ХУД, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө. УБ-36, ш/х-811 | Номын санч В.Арвинжаргал-96662076 | | | Б.Бат-Эрдэнэ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 15 | Техник технологийн дээд сургуулийн номын сан | УБ, БГД, 5-р хороо,10-р хороолол,Энхтай ваны өргөн чөлөө-44 | Захирал-Л.Цолмончимэг -Лицей сургууль-Ундармаа-99189315 | | | Г.Баяртуяа |
| 16 | Хөгжим бүжгийн коллежийн номын сан | УБ, БЗД, 5-р хороо, 13-р хороолол, Намянжугийн гудамж | Оюунбилэг эрхлэгч-99161700 | 2017.12.24-30 | 2018 оны 7-8-р сар | Б.Бат-Эрдэнэ |
| 17 | Цэцээ гүн дээд сургуулийн номын сан | УБ, БЗД, 13-р хороо, БЗД-ийн татварын газрын зүүн урд талд. Цэцээ гүн коллежийн байр | Эрхлэгч: Буджав-91996625 | | | Г.Баяртуяа |
| 18 | Шинэ АУДС-ийн номын сан | 18130, УБ, СХД 20-р хороо, Сонсголонгийн зам-12/А | Номын санч Б.Ринцэндулам-95920888 | | | Б.Бат-Эрдэнэ |
| 19 | Технологийн дээд сургуулийн номын сан | УБ, ХУД, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж-26, УБ-36, ш/х-197 | Номын санч: Сүрэн-99133160 | 2018.01.5-10 | 2018 оны 9-10-р сар | Г.Баяртуяа |
| 20 | Сити их сургуулийн номын сан | УБ, СБД, 7-р хороо, 11-р хороолол | 77472244 | | | Б.Бат-Эрдэнэ |
| 21 | ХИС-ийн харъяа Билиг дээд сургууль | 260620А, УБ, СБД, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө-7/4. | Номын санч: Цогтойцэцэг-96481123 | | | Г.Баяртуяа |
| | | | | | | |
| 22 | Отгонтэнгэр их сургуулийн номын сан | 210351, УБ, БЗД, Энхтайваны өргөн чөлөө, Жуковын гудамж-51, ш/х-35 | Эрхлэгч: Навчаа: 95670299 | | | Б.Бат-Эрдэнэ |

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: .................... /Г.БАЯРТУЯА/
.................... /Б.БАТ-ЭРДЭНЭ/
.................... /Б.ТУНГАЛАГ/

ХЯНАСАН: .................... ТӨСЛИЙН УДИРДАГЧ Ж.ЦЭЗЭН

УЛААНБААТАР ХОТ



**“Дээд боловсролын салбарын цахим нэгдсэн номын сангийн төсөл”-**ийн “Коха” программ хариуцсан ажилтан **Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа** нар төсөлд хамрагдах боломжийг судлах зорилгоор 2017 онд нийт 20 их дээд сургуулийн номын санд очиж судалгаа авч зөвлөгөө өгөн ажилласан. Тус судалгааг үндэслэн “Эрдэм судлал”-д туслах цахим мэдээллийн нэгдсэн санд хамрагдах байгууллага, номын санч, бүтээлийн тоог тодорхой гаргаж, бэлэн байгаа баазыг хөрвүүлэх ажил эхэлж байгаа юм.

**Ажлын гүйцэтгэл дараах 3 үе шаттайгаар амжилттай хийгдлээ:**

**I.** Төсөлт хамрагдсан их дээд сургуулийн программыг шинэчлэх, зөвлөгөө өгөх, Сургалтын материалыг ялгаж хөрвүүлэхэд бэлэн болгох ажлын явц /Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа, Б.Тунгалаг/

**II.** Төсөлд хамрагдсан материалыг “Коха” программд жигд хөрвүүлж ашиглахад бэлэн болгох ажлын явц /Н.Мөнхцэцэг-гадны байгууллагаар гүйцэтгүүлэх ажил/

**III**. Төсөлд хамрагдсан 20 сургуулийн номын сан дахь **19.405** ширхэг сургалтын хэрэглэгдэхүүн ба “МУҮНС-ийн цахим диссертаци”**-11.577** ширхэг докторын

диссертаци, нийт **30,982** баримтын **“Эрдэм судлал”** нэртэй цахим мэдээллийн санг буй болгосныг нэгдсэн сүлжээнд холбох, оролцогч номын санд эрх олгох, программын аюулгүй байдлыг ханган ажиллахыг төслийн гүйцэтгэгч байгууллага /МУҮНС: Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа/ хариуцан ажиллав. Мөн шинээр хүсэлт гаргасан Ерөнхий боловсролын 3 сургуульд цахим сүлжээний эрх олгож, цаашид цахим мэдээллийн санг үүсгэх ажлын аргазүйг сургалтаар олгон ажиллаа.

**1. Төсөлт хамрагдсан их дээд сургуулийн программыг шинэчлэх, зөвлөгөө өгөх, Сургалтын материалыг ялгаж хөрвүүлэхэд бэлэн болгох ажлын явц-II.**

Төсөлд хамрагдсан их дээд сургуулийн номын сангуудын сургалтын баазыг судалж, сургалт, аргазүйг боловсруулан ажиллах, LIB4U, CDISIS зэрэг бусад цахим программд олон янзаар орсон сургалтын хэрэглэгдэхүүнийг судалж түүвэрлэн гаргах ажлыг сургууль тус бүр дээр хийж гүйцэтгэв. Зардлын төсөвийг 2018 оны 01-р сарын 1-10-р сарын 1 хүртэл тооцож /Санхүүгийн тайланд үзнэ үү/ ажиллуулав. Мөн энэ үеэр социологийн судалгаа авах үүрэгт ажлыг Бат.Тунгалагт давхар хариуцуулан ажиллуулав. Социологийн судалгаагаар 22 сургуулийн цахим хариуцсан номын санчдаас судалгаа авч нэгтгэхэд дараах дүгнэлт гарч байна.

**Социологийн судалгаа №4**

**Дүгнэлт:** Монгол улсад хэвлэгдсэн болон монгол эрдэмтдийн бүтээл, өгүүллийн нэгдсэн сан үүсч байгаад нийт оролцогчдын 98 % нь талархан дэмжиж, ийм цаг үед “ДБСЦННС” хэмээх төсөл хэрэгжиж байгаа нь тун сайшаалтай гэж нэмэлт тэмдэглэл хийж ирүүлсэн байна. Дээд боловсролын төсөлд хамрагдаж хамтран ажилласан 20 сургууль номын санч мэдээллийн ажилтнууд, инженерүүдээ өргөнөөр хамруулсан явдал санал асуулгаас бодитой дүгнэлт хийх боломжоо олдлоо.

1. *"МУҮНС-ийн монгол хөрвүүлэгтэй Коха программтай нэгдэхийг хүсэж байна уу?* гэсэн асуултанд тийм гэж 24 хүнээс **21** хүн хамгийн их санал өгснөөс үзвэл энэхүү төсөл нь цагаа олсон, дээд боловсролын сургалтын байгууллагын номын санч мэдээллийн ажилтнуудын хүсэн хүлээж байсан, нэн шаардлагатай төсөл болжээ гэж үзэж байна.
2. “Танай номын сангийн сургалтын материалыг “Коха” руу хөрвүүлэхэд сургуулийн удирдлага дэмжих үү?” гэсэн асуултанд 24 хүнээс 20 дэмжинэ гэж хариулсанаас үзвэл төслийн эхэн үед төдийлөн идэвхгүй байсан удирдлага төслийн эцчийн үр дүнг дэмжиж Нэгдсэн мэдээллийн сан, нэг хайлтын сүлжээний ач тусыг ойлгож хамтарч ажиллахыг хүсэж байгаа нь харагдлаа.

3. *“МУҮНС-ийн монгол хөрвүүлэгтэй Кохад сургалтын материалыг хөрвүүлэх хэрэгцээ сонирхол?* гэсэн асуултанд 24-19 нь сонирхолтой гэж санал өгсөн нь Монгол хөрвүүлэгтэй хайлтын систем нэн чухал гэж дүгнэх боломжтой. Үүнээс гадна өөрсдийн хэрэглэж буй мэдээллийн баазаас export хийн гаргаж, МУҮНС-ийн КОХА-д import-лон оруулснаар дахин ном, бүтээлийг шивж оруулах шаардлагагүй, цаг хугацаа хөрөнгө мөнгө, ажиллах хүч хэмнэсэн тул хөрвүүлэн оруулах сонирхолтой байна.
4. *“МУҮНС-ийн монгол хөрвүүлэгтэй Коха программын талаарх мэдээлэл?”* гэсэн асуултад “ Сайн 24-**17** хариулсанаас үзвэл монгол хэл дээрх Коха программын хэрэглээ өссөн нэмэгдэх хандлагатай байна.
5. *"Танай номын сангийн сургалтын материал аль нэгэн цахимд орсон эсэх”* ? гэсэн асуултад Бүгд орсон **-13,** Хагас нь орсон**-7,** Огт ороогүй-2 гэсэн хариултаас харахад нилээд сургууль бүтээлийн эзэн оюуны өмчлөгч багш оюутнуудтайгаа нягт хамтын ажиллагаатай ажилладаг сургуулийн давуу талыг харуулж байна.
6. “Танай номын сангаас цахимаар ном захиалах, олгох ажил хэрхэн явагддаг үнэлгээ?**”** гэсэн асуултад Сайн-10, Дунд- 5 Муу-9 гэж хариулжээ. Энэ нь сургуулийн номын сангуудын цахим захиалга нилээд хүчээ авч шат шатандаа хэрэгжиж эхлээд байгааг харуулж байна.
7. “Коха” программд дээр ажиллах мэргэжлийн ажилтантай эсэх? Тийм-8, Үгүй-16 гэж хариулсанаас үзвэл номын санч бэлтгэдэг мэргэжлийн сургуулиуд өөр сургуулиудад төгсөж байгаа инженер техникийн ажилтнаас гадна номын сангийн сүлжээний инженер, системийн инженер, техник инженерийн түлхүү бэлтгэх шаардлагатайг сануулж байна.

8.“ Цөөн хувьтай ховор номыг бүтэн бичвэрээр цахимд шилжүүлсэн үү? Тийм-6, үгүй-18 хариулсанаас үзвэл Зохиогчийн эрх оюуны өмчийн хуульд захирагдаж ажил явагддагаас ном бүтээл бүрэн эхээрээ төдийлөн цахим болж чадаагүйг харуулж байна.

9.Танай номын сангийн техникийн хүчин чадал? Сайн-5, Дунд-6, Муу-13 гэж хариулсанаас үзвэл Ихэнх байгууллагт нийтлэг тохиолддог интернэтийн хурд, техникийн хүчин чадал муу байгаа нь санхүү хөрөнгөөс хараат хамааралтайг харуулж байна.

**Нэгдсэн дүгнэлт**

**БАТЛАВ: Төслийн удирдагч Доктор Ж.Цээн**

**Социологийн судалгаа №4**

**Санал асуулгын зорилго:**

Энэхүү төслийг хэрэгжүүлэх боломж нөхцөл хэр зэрэг бүрдсэн

Төсөлд нэгдэн орох эрэлт шаардлагад үнэлгээ өгөх

Төслийн дараагийн шатны үйл ажиллагааг үр ашигтай явуулахад оршино

*(Өмнөх үсгийг дугуйлах буюу нөхөж бичнэ үү?)*

1. "Коха" программ дээр ажиллах мэргэжлийн ажилтантай эсэх?

а.тийм б.үгүй

2. МУҮНС-ийн монгол хөрвүүлэгтэй Коха программын талаарх мэдээлэл?

а.сайн б.дунд. в.мэдэхгүй

3. Танай номын сангийн сургалтын материал аль нэгэн цахимд орсон эсэх?

а. бүгд орсон б. хагас нь орсон в.огт ороогүй

4. МУҮНС-ийн монгол хөрвүүлэгтэй Кохад сургалтын материалыг хөрвүүлэх хэрэгцээ, сонирхол?

а. хөрвүүлэх нь чухал б. одоогийн программаар байх нь зөв

5. МУҮНС-ийн монгол хөрвүүлэгтэй Коха программтай нэгдэхийг хүсэж байна уу?

а.тийм б.үгүй.

6. Танай номын сангийн сургалтын материалыг "Коха" руу хөрвүүлэхэд сургуулийн удирдлага дэмжих үү?

а. дэмжинэ б.дэмжихгүй в.мэдэхгүй

7. Танай номын сангаас цахимаар ном захиалах, олгох ажил хэрхэн явагддаг үнэлгээ?

а. сайн б. дунд в.муу

8. Танай номын сангийн техникийн хүчин чадал?

а.сайн б.дунд. в.муу

9. Цөөн хувьтай ховор номыг бүтэн бичвэрээр цахимд шилжүүлсэн үү?

а. тийм б.үгүй

9. Үгүй бол яагаад?

а. сургууль зөвшөөрдөггүй, б.зохиогч зөвшөөрдөггүй, в.зохиогчийн гэрээ байхгүй

10. Кохад бүтэн бичвэрээр орсон номыг хуулбарлахгүй байх боломж бий юу?

а. хуулбарлах боломжгүй б.хуулбарлана

11. Бусад номын сангаас ном захиалан унших боломжийн талаар таны санал:

______________________________________________________________________________

12. "Дээд боловсролын цахим нэгдсэн номын сан" төслийн давуу сул талыг үнэлэнэ ??

______________________________________________________________________________

*Танд баярллаа*
*2018.10.1*

Санал асуулгад оролцогчдын өгсөн хариултыг тоон статистикийн аргаар боловсруулсан бидний ажлын дүн мэдээнээс харвал Улс орон даяар номын сангуудын Цахим мэдээллийн сангийн эрэлт хэрэгцээ ихсэж, нэн чухал шаардлагатай үед "Дээд боловсролын салбарын цахим нэгдсэн номын сан" төсөл хэрэгжиж төслийн хүрээнд ганцаарчилсан болон нийтийн сургалтууд удаа дараа явагдаж, нэгдсэн нэг программ, ангилалтай нэг сүлжээнд орохын эхлэл тавигдсан нь үйл ажиллагааг улам сайжруулах эхлүүлсэн ажлыг тасралтгүй явуулах шаардлагатайг харуулж байна гэж манай ажлын хэсэг үзсэн болно. Цаашид үлдсэн их дээд сургуулиудыг нэгдсэн мэдээллийн санд нэгтгэх ажлыг зохион байгуулах шаардлагатай гэж харж байна.

АЖЛЫН ХЭСЭГ. 2018.11.25

Дараагийн шатанд 2018 оны 10-р сараас он дуустал сургуулиудаар явж ажлын гүйцэтгэл, номын санчид мэдээллээ оруулж байгаа бодит байдалд хяналт хийх, сургалт-III- аар хэлэлцэх асуудлыг нэгтгэх ажилд зориулан Б.Бат-Эрдэнэ, Ж.Тунгалаг, Ж.Цэзэн, Баяртуяа /Одхүү/ нар явж амжилттай ажиллаа.

Дотоод томилолт I,II,III бүхэлдээ энэхүү төслийн гүйцэтгэлд шийдвэрлэх үүрэгтэй, нарийн чимхлүүр ажилбар ихтэй байсан тул зуны амралтаар дамнан ажилласныг тэмдэглэх нь зүйтэй. Уг ажлын хүрээнд сургууль тус бүр дээр очиж номын санчид зааварчилгаа өгөх, тодорхой нэг номын санчид эрх өгч түүгээр дамжуулан мэдээлэл солилцох боломжтой гэж үзсэн тул МУҮНС-аас холбогдох номын санчийн нэрээр эрх нээх, индекс олгох ажил явагдав. Мөн өөрийн хүчээр хийж чадахгүй зарим ажил, тухайлбал, сургалтын материалыг Кохад хөрвүүлэх ажлыг гадны байгууллагаар хийж гүйцэтгүүлэх, сургалт зөвлөгөө авах зэрэг бусад ажлыг шийдвэрлэсэн. Зарим ажлыг МУҮНС-ийн цахим дээр турших хийснээр бусад их дээд сургуулиудад зөвлөгөө өгөх боломж бүрдэж байв. Жишээ нь: Ноот ба газрын зургийн материалыг хэрхэн оруулах асуудал гарсан тул Б.Бат-Эрдэнэ МУҮНС-ийн цахимд 138 нэрийн баримтыг оруулж туршсан зэрэг ажлууд хийгдлээ.

**Гадны байгууллага, хүмүүсээр гүйцэтгүүлсэн ажил**

Бид төслийн явцад МУҮНС болон төслийн багийн гишүүдийн хүчээр хийж гүйцэтгэж чадахааргүй зарим ажлыг мэргэжлийн байгууллага, хүмүүсээр захиалан хийлгэх, сургалт, зөвлөгөө авах замаар амжилттай гүйцэтгэж тодрорхой үр дүнд хүрэв. Үүнд:

**2. Дээд боловсролын байгууллагын номын сан дахь сургалтын материалыг “Коха” программд хөрвүүлэх ажлыг захиалан хийлгэв.**

Дээд боловсролын байгууллагын номын сангуудын нийт мэдээллийн баазаас зөвхөн эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн баазыг Коха программд **хөрвүүлэх** ажлыг 2018 оны 02-р сарын 5-аас 2018 оны 12-р сарын 5 хүртэл гадны байгууллагаар хийж гүйцэтгэх захиалгат ажлын хүрээнд МУИС-ийн мэргэжилтэн инженер Намсрайдоржийн Мөнхцэцэгээр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж санхүүжүүлэн ажиллав. /МУҮНС-ийн мэргэжилтэн Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа болон Мониторингийн тайлан хэлэлцэх үеэр ШУТС-ийн мэргэжилтэн нарын зөвлөснөөр/

**“Коха”-**программыг МУИС болон бусад их дээд сургуулийн номын сангуудад нэвтрүүлэн ашиглах талаар амжилттай ажиллаж байгаа Намсрайдорж овогтой Мөнхцэцэгийг МУҮНС-ийн “Коха”-г дээд боловсролын номын санд нэвтрүүлэх төсөлд ажиллаж байгаа Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа нарын хүсэлтээр тэдэнтэй 2017.12-р сарын 1-нд 3 тоот гэрээг дам байгуулж, улмаар 2018 оны 02-р сарын 1-нд Н.Мөнхцэцэгтэй шууд гэрээ байгуулж, дараах төлөвлөгөөний дагуу ажил үүрэг гүйцэтгэв.

**Зураг №24 Гэрээт ажилтны уулзалт-Сургалтын материал Кохад хөрвүүлэх ажилтан Н.Мөнхцэцэгтэй гэрээ хийх үйл ажиллагаа /2018.02.1/**



**“Коха” программын мэргэжилтэн Н.Мөнхцэцэгийн гүйцэтгэсэн ажил:**

Юуны өмнө Монгол улсын үндэсний номын сангийн цахим каталогит орсон их дээд сургуулиудын цахим доктор болон магистрын ажлууд зэрэг сургалтын материалыг сонгон авч цахим каталогт хөрвүүлэн ажиллав.

Монголын үндэсний номын сан нь номын сангийн Коха системтэй. Коха систем нь вэбэд суурилсан учраас интернэтээр хаанаас ч хандах боломжтой. Энэ ажлын чухал үзүүлэлт бол Үндэсний номын сангийн “Эрдэм судлал” нэртэй мэдээллийн санд Дээд боловсролын салбарын номын санд буй д магистрын болон докторын ажил гэсэн хувилбартай мэдээллийн санг холбож хөрвүүлсэн явдал болно. Ингэж хөрвүүлэх ажил маш нарийн төвөгтэй тул мэргэжлийн инженерийн түвшинд хийгдсэн болно. Коха систем нь номзүйн Marc-21 бичлэгийн дагуу каталогичилдаг.

**Хүснэгт:2 Монголын их дээд сургуулиудийн номын сангийн сургалтын материалын цахимжуулсан үзүүлэлт**

| **№** | **Сургуулийн нэр** | **Хөрвүүлсэн эрдэм судлалд туслах баримт** | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **Бакалавр** | **Магистр** | **Доктор** | **ЭШЭ** | **Нийт** |
| **1** | АШУИС-ийн номын сан | - | 873 | 413 | - | 1286 |
| **2** | Мандах их сургууль | 2313 | 250 | - | - | (Давхардсан тоогоор 2563) |
| **3** | МУИС-ийн номын сан | | 4779<br>e_mag 1885 | 677 | - | 7341 |
| **4** | Монгол Улсын консерватийн -ийн номын сан | 488 | - | - | - | 488 |
| **5** | Монголын Үндэсний Их Сургуулийн номын сан | 726 | - | - | - | 726 |
| **6** | Монос ДС-ийн номын сан | 97 | - | - | - | 97 |
| **7** | Олон улс Улаанбаатар Их сургуулийн номын сан | 804 | 8 | - | 549 | 1361 |
| **8** | Олон улсын эдийн засаг, бизнесийн дээд сургуулийн номын сан | 264 | - | - | - | 264 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **9** | Отгонтэнгэр их сургууль | 2 | 2 | - | - | 4 |
| **10** | СУИС-ийн номын сан | - | 641 | 38 | - | 679 |
| **11** | СУИС-ийн Соёлын сургуулийн номын сан | | | | | |
| **12** | Техник технологийн дээд сургууль | 2 | - | - | - | 2 |
| **13** | Технологийн дээд сургууль | 2 | - | - | - | 2 |
| **14** | Улаанбаатар Их сургуулийн /төрийн/ номын сан | 1053 | 562 | - | - | 1615 |
| **15** | ҮБХИС-ийн номын сан | - | 301 | 73 | - | 374 |
| **16** | Хангай дээд сургуулийн номын сан | 135 | | | | (Давхардсан тоогоор 135) |
| **17** | ХААИС-ийн төв номын сан | - | 1549 | Англи 3<br>Монгол 338<br>Орос 33 | - | 1923 |
| **18** | Цэцээ гүн дээд сургуулийн номын сан | 43 | 131 | - | - | 174 |
| **19** | Шинэ Анагаах ухаан дээд сургуулийн номын сан | 367 | - | - | | 367 |
| **20** | Этүгэн их сургууль | 2 | 2 | - | - | 4 |
| **21** | Чингэлтэй дүүргийн Номын өргөө | - | - | - | - | - |
| **22** | ХУД-ийн лаборатори 18-р сургууль | - | - | - | - | - |
| **23** | ЧД-ийн лаборатори 23-р сургууль | - | - | - | - | - |
| **Дүн** | | **6298** | **10.983** | **1.575** | **549**[*] | **19.405** |

[*] Төсөлд хамрагдсан их дээд сургуулиудын Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлийн мэдээлэл тухайн сургуулийн цахим программд бүрэн орсон бөгөөд хайлт хийж ашиглагдах боломжтой. Энд ОУУБИС-аас бусад их дээд сургуулийн үзүүлэлтийг тэмдэглээгүй болно.

**Marc-21-ийн нэр томъёо, тэдгээрийн тодорхойлолтууд**

MARC (Machine Readable Cataloging reocord) бичлэг бол машинаар унших каталогчлалын бичлэг юм.

**Талбар**: Ном зүйн бичлэг нэг бүр талбаруудад хуваагдана. Зохиогчид зориулсан талбар, гарчгийн тухай мэдээллийн талбар г.м байна. Эдгээр талбарууд нэг буюу хэд хэдэн дэд талбаруудад хуваагдана.

**Тэмдэглээ**: Талбар бүр тэмдэглээ гэж нэрлэсэн гурван оронтой тоогоор илэрхийлэгдэнэ. Тэмдэглээ нь тэмдэглээний дараах талбарыг(өгөгдлийн төрөл) адилтгана. Тэмдэглээ үргэлж эхний 3 тоо байна. Хэрэв тэмдэглэгээ нэгээс илүү удаа ном зүйн бичлэгт давтагдах бол түүнийг давтагдах(R) гэж заана. Хэрэв тэмдэглэгээ бичлэгт зөвхөн нэг удаа ашиглагдах бол түүнийг үл давтагдах(NR) гэж заана.

**Индикатор**: Талбарын тэмдэглээ бүрийн дараа тэмдэгтийн 2 байрлал байна. (001-009 талбаруудаас бусад). Индикаторуудад тэмдэгтийн дан ганц буюу 2 байрлал ашиглагдаж болно. Талбарын онцлогоос хамаарч 1-р байрлал, 2-р байрлал эсвэл 2байрлал хоёулаа ч хэрэглэгдэхгүй байж болно. Хэрэв индикаторын байрлал ашиглагдахгүй бол ‘тодорхойгүй’ гэдгийг хоосон эсвэл # тэмдэгтээр заана. Индикатор тус бүрийн утга нь 0-9 хүртэлх тоо байна.(Цөөн тохиолдолд үсэг байдаг.)

**Дэд талбар**: Дийлэнх талбарууд хэд хэдэн тусгай харилцан холбоотой өгөгдлүүдийг агуулна. Талбар дахь өгөгдлийн төрөл тус бүрийн дэд талбар, дэд талбар бүрт дэд талбарын код байна. 001-009 хүртэлх талбарууд дэд талбаргүй. **Дэд талбарын код**: Дэд талбарын код нь өмнөө дэд талбарын тусгаарлагчтай доод регистрын нэг үсэг байна. Дэд талбарын код тус бүр түүний дараа ямар төрлийн өгөгдлүүд гарч ирэхийг заана. Тусгаарлагч нь ихэвчлэн $ тэмдэгт байна.

**Схем №1 Marc-21-ийн нэр томъёо, тодорхойлолтууд**




**Marc-21-ийн тогтмол хэрэглэгддэг талбаруудын товч тодорхойлолт:**

**020 ISBN - Олон улсын стандартчлагдсан номын дугаар**

(R - өөрөөр хэлбэл давтагдах ) индикаторууд үл тодорхойлов.

$a Олон улсын стандартчлагдсан номын дугаар

$c Худалдан авах нөхцөл (Тогтмол үнэ)

**084** **Other Classification Number** (R) – Ангилалын шифр. Индикаторууд үл тодорхойлов.

$a Classification number (R) – Ангилалын дугаар (Шифр. Жнь: ББК22.19/Ж-27)

$b Item number (NR) – Код (Жнь: 72333)

**100** **Main entry – Personal name** (NR) – Зохиогчийн нэр

Индикатор1: оролтын элемент болох хүний нэрийн төрөл

0 – Хувь хүний өөрийн нэр

1 – Энгийн овог

2 – Нийлмэл овог

3 – Удамын нэр

Индикатор2: тодорхойлоогүй.

$a Хүний нэр

$b Дугаарлалт

$c Цол ба хүний нэртэй холбогдох бусад үгс

$d Хүний нэртэй холбоотой огноо(гол төлөв – төрсөн он)

**245 Title statement** (NR) – Гарчгийн тухай мэдээ

Индикатор1: Гарчигт зориулсан ном зүйн нэмэлт бичлэг

0-Зохиогчгүй үндсэн бичлэг үйлдэхийг заана.

1-Зохиогч 100 талбарт байгаа тохиолдолд индикаторыг ашиглана.

Индикатор2: Тогтмол 0 байхад болно.

$a Title – Үнэдсэн гарчиг

$c Statement of responsibility, etc  - нүүр хуудаснаас хуулбарласан бусад мэдээ, хариуцлагын мэдээ(Жнь: редактор, спонсор)

**246 Varying form of title** (R) – Гарчгийн өөр хэлбэр

Индикатор1:

Индикатор2:  Индикатор үл тодорхойлов.

$a Title proper/Short title – Богино гарчиг (Жнь: Түлхүүр үг, Ерөнхий нэр)

**250 Edition statement** (NR) – хэвлэлийн тухай мэдээлэл. Индикаторууд үл тодорхойлов.

$a Edition statement – Хэвлэлийн тухай мэдээлэл. (Жнь: imprint)

**260 Publication, Distribution, etc** (NR) – Хэвлэл нийтлэл, түгээлт г.м. Индикаторууд үл тодорхойлов.

$a Place of publication – Хэвлэлийн газар

$b Name of publisher – Хэвлэгчийн нэр

$c Date of publication – Хэвлэгдсэн огноо

**300 Physical description** (R) – Биет тодорхойлолт. Индикаторууд үл тодорхойлов.

$a Extent- Хуудасны тоо

$b Other physical details – Бусад биет шинжүүд (Зургийн биет шинж)

$c Dimensions – хэмжээнүүд (см)

**500 General note** (R) – Ерөнхий тайлбар. Индикаторууд үл тодорхойлов.

$a General note – Ерөнхий тайлбар (Жнь: Note – Дансны дугаар)

**520 Summary, etc** (R) – Товч тайлбар. Индикаторууд үл тодорхойлов.

$a Summary - Товч тайлбар (Жнь: AccountPointer - Данс заагч)

**650 Subject added entry** (R) – Сэдэвчилсэн, зүйлчилсэн гарчиг

Индикатор1: Индикатор үл тодорхойлов.

Индикатор2: Зүйлчилсэн гарчгийн систем.

0 – Конгрессын номын сангийн зүйлчилсэн гарчгууд

1 – Хүүхдийн уран зохиолд зориулсан КНС-н зүйлчилсэн гарчгууд

2 – Анагаах ухааны зүйлчилсэн гарчгууд

3 – Үнэсний хөдөө аж ахуйн номын сангийн зүйлчилсэн албан ёсны файл

4 – Үүсвэр тодорхой биш

5 – Канадын номын сангийн зүйлчилсэн гарчиг

$a Topical term or geometric name as entry element – Сэдэвчилсэн нэр томъёо (Жнь: title)

**Бид доорх талбаруудтай марк бичлэгүүдийг үүсгэсэн.**

=LDR  02007nam a22002417a 4500

**Ямар хэл дээр бичигдсэн**

=008  120406t\\\\\\\\mp\|||||\||||\00|\0\mon\d

=041  \\$amon$hmon

=084  \\$2ББК$a67.407 75$bЦ-94

**Горилогчийн нэр**

=100  \\$aЦэлмэг Ц.

=110  \\$aМонгол Улсын Их Сургууль

**Аль сургуулийн номын санд**

=245  \\$aОйн эрүүгийн эрх зүйн хамгаалалтын үндсэн асуудал$bДокторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл$cЭрдэм шинжилгээний удирдагч Жанцан С, БаярсайханД.

**Диссертацийн**

=260  \\$aУлаанбаатар$c2012

**Хамгаалсан огноо**

=300  \\$a140 хууд.

=500  \\$aД-166

=502  \\$cМонгол Улсын Их Сургууль

=520  \\$adic

**Хайлтын түлхүүр үгс**

=653  \\$ахууль

=653  \\$аойн хамгаалалт

=653  \\$аойн эрүүгийн хамгаалалт

**Ерөнхий тайлбар**

=740  \\$aОйг хамгаалах төрийн бодлогын ерөнхий шинж төлөв$a"Ойн тухай хууль тогтоомж зөрчих" гэмт хэргийн онцлог шинж $a Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн криминологи судалгаа $a Дүгнэлт $a Хавсралт судалгаанууд $a

Диссертацийн хураангуй англи хэл дээр $а Ойг хамгаалах төрийн бодлогын ерөнхий шинж төлөв $а "Ойн тухай хууль тогтоомж зөрчих" гэмт хэргийн онцлог шинж $а Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн криминологи судалгаа $а Дүгнэлт $а Хавсралт судалгаанууд $а Диссертацийн хураангуй англи хэл дээр

=942 \\$cDIS

=952 \\$00$10$2rubBK$40$693166

Төрөл, дансны дугаар, баркод гэх зэрэг нэмэлт мэдээлэл

Үндэсний номын сангаас нээж өгсөн номын санчийн эрхээр номын санчид нэвтэрч ороод өөрсдийн диссертаци болон магистрын ажлын цахим каталогийг засварлах боломжтой. Жишээгээр харуулбал :

**“Эрдэм судлал” сан хөмрөгөөс Соёл Урлагийн Их Сургуулийн диссертаци болон магистрын ажлуудын**

**цахим катологийг харуулсан байдал.**




Үйлчилгээ Үйлчлүүлэгчид Хайх Карт Нэмэлт
koha_library | НОМЫН САН СОНГОГДООГҮЙ БАЙНА
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САН
Хайлтын түлхүүр үгүүдийг оруулах:
ti=
Submit
Уншлаганд гаргах Буцаалт хийх Каталог хайх
Үндсэн › Каталог › Хайх for 'kw,wrdl: соёл урлагийн их сургууль'
Хайлтыг сайжруулах
Бэлэн байдал
Хязгаарлагдсанодоогоор бэлэн байгаа зүйлс
Authors
Баасанхүү Ч.
Соёл урлагийн их сур...
Содоо Ж.
СУИС, Дүрслэх, дизай...
СУИС, Хөгжмийн урлаг...
Show more
Topics
Хөгжмийн онол, түүх
Home libraries
Архив фонд
Эрдэм судлал
Монгол судлал
Зүйлийн төрөл
ARC
Диссертаци
Магистрын ажил
722 бичлэг олдсон for 'kw,wrdl: соёл урлагийн их сургууль'.
Sort By: Title (Z-A)
Бүгдийг сонгох | Бүгдийг цэвэрлэх | Идэвхжүүлэлтийг болох | Нэмэх: Хадгалах Захиалга өгөх Z39.50 хайлт
Үр дүн
Байршил
1. Ятгын хөг, хөгжимдөх онцлог
by Баасанхүү Ч. Соёл урлагийн их сургууль. Соёл урлагийн их сургууль
Материалын төрөл: Ном; Формат: хэвлэх; Literary form: зөгнөлт биш
Хэвлэлийн газар:УБ 2006
Тайлбар: 66х., 9 нүүр нот, 10 нүүр зур.
Захиалга | Ангилал тодорхойлох | Ном бүртгэх
1 ном, 1 ашиглах боломжтой:
[206] (1)
Магистрын ажил
2. Ятгын мэргэжлийн сургалт Монголд үүсч хөгжсөн нь
by Нямсүрэн Д. Соёл урлагийн их сургууль. Соёл урлагийн их сургууль
Материалын төрөл: Ном; Формат: хэвлэх; Literary form: зөгнөлт биш
Хэвлэлийн газар:УБ 2006
Тайлбар: 47х., 21 нүүр зур.
Захиалга | Ангилал тодорхойлох | Ном бүртгэх
1 ном, 1 ашиглах боломжтой:
[212] (1)
Магистрын ажил
3. Ятга хөгжмийн сурах бичиг
by Баасанхүү Ч.
Хэвлэлийн газар: УБ ; УБ ; Арилдал ; 2008
Тайлбар: 296х.
ISBN: ISBN 99929-886-1-4.
Бусад гарчиг:, ятга хөгжмийн урын сан-1.
Захиалга | Ангилал тодорхойлох | Ном бүртгэх
1 ном, 1 ашиглах боломжтой:
11 [28301] (1)
4. Яруу найрал хөгжмөөс холимог найрал хөгжимд хөрвүүлэх онцлог /Л.Мөрдоржийн "Хөхөө Намжил" дуурийн удирдварын жишээн дээр/ Урлаг судлалын магистрын зэрэг горилсон бүтээлийн бичвэр /30%
by Даваасүрэн Н. Соёл урлагийн их сургууль. СУИС, Хөгжмийн урлагийн сургууль
Материалын төрөл: Ном; Формат: хэвлэх; Literary form: зөгнөлт биш
Хэвлэлийн газар:УБ 2016
Тайлбар: 28х. А4 Хавсралт
1 ном, 1 ашиглах боломжтой:
[531] (1)
Магистрын ажил


Үйлчилгээ Үйлчлүүлэгчид Хайх Карт Нэмэлт
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САН
Хайлтын түлхүүр үгүүдийг оруулах:
ti=
Submit
Уншлаганд гаргах Буцаалт хийх Каталог хайх
Үндсэн › Каталог › ДэлгэрэнгүйЯтгын хөг, хөгжимдөх онцлог
Хайлтын үр дүнрүү буцах
« Өмнөх
Дараагийн »
Хэвийн
MARC
КАРТ
Ном
Захиалга
Уншлаганд авсан номнууд
Өөрчлөлтийн архив
Шинэ Засварлах Save Нэмэх Хэвлэх Захиалга өгөх
Ятгын хөг, хөгжимдөх онцлог
ЗохиогчБаасанхүү Ч. Соёл урлагийн их сургууль; Соёл урлагийн их сургууль.
Материалын төрөл: Ном
Хэвлэлийн газар:УБ 2006
Тайлбар: 66х., 9 нүүр нот, 10 нүүр зур.
Uniform titles: 787 Б 109.
Subject(s): ятга | ятгын хөг | магистрын ажил
Диссертацийн санамж:Соёл урлагийн их сургууль
MARC бичлэгийн харах: Show
Картын дугаар
Үйлчлүүлэгчийн дугаар 0
Захиалга Данс заагч Зураг
Бүгдийг сонгох | Бүгдийг цэвэрлэх
Шүүлтүүрийг идэвхжүүлэх
Зүйлийн төрөл | Одоогийн байршил: | Үндсэн номын сан | Дансны дугаар | Төлөв | Тооллогдсон огноо | Бар код | Засварлах
Магистрын ажил | Эрдэм судлал | Эрдэм судлал | 206 | Бэлэн байна | 2017-06-05 | 14034095 | Засварлах
There is no order for this biblio.
Зохиогч нь Соёл Урлагийн Их Сургууль
Цахим каталогийн бүртгэл нь ҮН-н эрдэм судлалын сан хөмрөг




Төслийн явцад Их дээд сургуулийн удирдлага, номын сангуудад албан тоот явуулж харилцан зөвлөлдөх, МУҮНС-ийн монгол хувилбартай "Коха" программыг тайлбарлах, төсөлд хамрагдсан сургуулиудын хуучин программаас сургалтын материалыг татах, хөрвүүлэх, цахим программын цаашдын нутагшлыг судлах, турших, төслийг тайлагнах зэрэг олон ажлыг тогтвортой хөгжүүлэх үүднээс гадны байгууллагуудын дэмжлэг туслалцаа, зөвлөгөө авч ажиллав. Үүний үр дүнд үндсэн 5 даалгавар амжилттай хэрэгжсэнээр төслөөр гүйцэтгэсэн "Эрдэм судлал" нэгдсэн сүлжээтэй боллоо. /Төсөлд хамрагдаагүй бусд 20 гаруй их дээд, нийтийн ба ЕБС-ийн номын сангууд төслийн санаагаар номын сангийн мэдээллийг хуримтлуулан, олон улсын нэгдсэн ангилалд нэвтрэн орж ажиллаж эхэллээ/

**3. “Эрдэм судлал” мэдээллийн нэгдсэн санг хамтран ашиглах, нэгдсэн сүлжээнд холбох, оролцогч номын санд эрх олгох ажил**

Хөрвүүлэх ажил дуусмагц МУҮНС-аас /төсөл гүйцэтгэгч байгууллагаас/ холбогдох их дээд сургуулийн мэдээллийн баазыг хүлээн авах, тодорхой нэр бүхий номзүйч нарт нэвтрэх эрх олгох, МУҮНС-ийн цахим диссертацийн мэдээллийн баазыг хянах, программ хангамжийн аюулгүй байдлыг хангах, архив сан үүсгэн backup хийх ажлыг гэрээт ажилтан Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа нар төлөвлөн гүйцэтгэв.

**Төслийн гүйцэтгэгч байгууллагаас /МУҮНС/ хийх ажлын даалгавар**

<table>
<tr><th>№</th><th>Нэр</th><th>Хугацаа</th><th>Гүйцэтгэх ажилтан</th></tr>
<tr><td>1</td><td>Төсөлд хамрагдсан 20 их дээд боловсролын байгууллагын номын сангийн “КОХА”-д Эрдэм судлалд туслах номзүйн мэдээллийн сан үүсгэх</td><td rowspan="3">2018.01.26-31</td><td rowspan="5">Т.Наранзул</td></tr>
<tr><td>2</td><td>Төсөлд хамрагдсан Их, дээд сургуулиудаар дэд талбар үүсгэх</td></tr>
<tr><td>3</td><td>Төсөлд хамрагдсан Их, дээд сургуулиудын номын санч нарт нэвтрэх эрх олгох</td></tr>
<tr><td>4</td><td>Анхаарч ажиллах зөвлөмж гаргах</td><td>2018.02.01-15</td></tr>
<tr><td>5</td><td>Программ хангамжийн аюулгүй байдлыг хангах, Архив сан үүсгэн backup хийх</td><td>2018</td></tr>
<tr><td>6</td><td>Хяналт тавих</td><td>2018</td><td>Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа<br>Б.Тунгалаг</td></tr>
</table>

Төлөвлөгөө гаргасан Б.Бат-Эрдэнэ
Г.Баяртуяа 2018.1-31

МУҮНС-ийн мэргэжилтэн Б.Бат-эрдэнэ, Г.Баяртуяа нар төсөлд хамрагдах номын сангуудын сургалтын материалыг хөрвүүлэх ажилд Коха программын мэргэжилтэн инженер Н.Мөнхцэцэгтэй хамтран дараах сургуулиудын номын санд биечлэн очиж, эрдэм судлалын бүтээлүүдийн бааз дээр ажилласан. Үүнд:

**Хүснэгт №3 Б.Бат-эрдэнэ, Г.Баяртуяа, Н.Мөнхцэцэг нарын ажлын хуваарь**

| № | Номын сангийн нэр | Биечлэн очсон хугацаа | Гүйцэтгэсэн | Ажлын даалгавар |
|---|---|---|---|---|
| 1 | АШУҮИС-ийн НС | 2018.01.12 (10.00-12.00) | Б.Бат-Эрдэнэ Г.Баяртуяа | Төслийн ажлын ач холбогдол, цаашид хийхгдэх ойрын болон хэтийн ажлын саналыг солилцов. /Marc21 –ийн талбарын зөрүүтэй байдал болон Z39.50 хэрэглээ, ISBD тохиргоо зэргийг нэгтгэх шаардлагатай байгаа зэрэг асуудлаар хэлэлцэв/ Коха системд оруулсан баазын экспорт импорт хийхэд талбарын зөрүүгүй болгох талаар харилцан тохиролцов. МУҮНС-ийн баазад оруул гэсэн хугацаанд оруулахаар зөвшөөрөв. |
| 2 | СУИС-ийн Төв НС | 2018.01.12 (13.00-15.00) | Б.Бат-Эрдэнэ Г.Баяртуяа | Marc21 –ийн талбарын зөрүүтэй байдал болон Z39.50 хэрэглээ, ISBD тохиргоо зэргийг нэгтгэх шаардлагатай байгаа зэрэг асуудлаар хэлэлцэв. Бэлтгэл ажил хангалтгүй байлаа. |
| 3 | МҮИС-ийн НС | 2018.02.12 (13.00-15.00) | Б.Бат-Эрдэнэ Г.Баяртуяа Н.Мөнхцэцэг | Lib4u програмаас Эрдэм шинжилгээний бүтээлүүдийн санд хөрвүүлэхээр Бакалаврын ажил, Магистрын ажил, Эрдэм шинжилгээний бүтээл нийт 726 экспортлон авлаа. Н.Мөнхцэцэг файлыг хүлээн авав. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | МУИС-ийн Төв НС | 2018.03.02 (12.00-16.00) | Б.Бат-Эрдэнэ Г.Баяртуяа | Marc21 –ийн талбарын зөрүүтэй байдал болон Z39.50 хэрэглээ, ISBD тохиргоо зэргийг нэгтгэх шаардлагатай байгаа зэрэг асуудлаар хэлэлцэв. Бэлтгэл ажлаа сайн хангахыг хүслээ. |
| 5 | Мандах бүртгэл дээд сургуулийн НС сан | 2018.02.13 (16.30-17.30) | Б.Бат-Эрдэнэ Г.Баяртуяа Н.Мөнхцэцэг | Lib4u програмаас Эрдэм шинжилгээний уншлагын танхимаас хөрвүүлэхээр Бакалаврын ажил, Магистрын ажил, Эрдэм шинжилгээний бүтээл нийт 3060 экспортлон авлаа. Н.Мөнхцэцэг файлыг хүлээн авав. |
| 6 | ЭЗШУИС-ийн НС | 2018.02.13 (14.00-15.30) | Б.Бат-Эрдэнэ Г.Баяртуяа Н.Мөнхцэцэг | Lib4u програмаас Эрдэм шинжилгээний бүтээлүүдийн электрон каталогийг хангалтгүй үүсгэсэн байсан тул гүйцэт оруулсны дараа эргэж холбогдон Экспорт хийж өгөхөөр шийдэв. |
| 7 | УБИС-ийн НС /захын хажууд/ | 2018.03.15 (15.00-17.00) | Б.Бат-Эрдэнэ Г.Баяртуяа Н.Мөнхцэцэг | Lib4u програмаас Эрдэм шинжилгээний бүтээлийн санд хөрвүүлэхээр Бакалаврын ажил 855, Магистрын ажил 565, Эрдэм шинжилгээний бүтээл 215 ширхэг нийт 1635 экспортлон авлаа. Н.Мөнхцэцэг файлыг хүлээн авав. |
| Тайлан бичсэн: Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа<br>2018.03.26 | | | | |

МУҮНС-д ашиглаж буй монгол хувилбартай “Коха” программыг их дээд сургуулийн номын сангуудад нэвтрүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүнийг уг программд хөрвүүлэх ажлын гүйцэтгэгч байгууллагаар ажилласан МУҮНС-аас Б.Бат-Эрдэнэ, Г.Баяртуяа нар хариуцан төслийн хүрээн дэх их дээд сургуулиудын нэр бүхий номын санчдад “Эрдэм судлал” мэдээллийн санд нэвтрэх эрх олгож, түүгээр дамжуулан уг мэдээллийн санг ашиглах боломжтой боллоо. Энэ нь уг төслийн гол үр дүн байв.

Ажлын үр дүнд нэр бүхий 20 сургууль, ЕБС-ийн 3 номын санчдад нэвтрэх эрхийг нээж олголоо.

**“Эрдэм судлал”-ын холбогдолтой цахим мэдээллийн сангийн сүлжээнд нэвтрэх эрх авсан номын санчдын нэр, сургууль, нэвтрэх кодыг доор харуулав:**

| № | Эрх бүхий номын санчид | Нэвтрэх код | Байгууллагын нэр |
|---|---|---|---|
| 1 | Арвинжаргал В | 0000000917 | “Хангай” дээд сургууль /ХДС/ |
| 2 | Даваа Ч | 0000000906 | “Отгонтэнгэр” их сургууль /ОИС/ |
| 3 | Дунал Б | 0000000919 | Соёлын сургууль /СС/ |
| 4 | Дэлгэрцэцэг Л | 0000000909 | “Мандах” их сургууль /МИС/ |
| 5 | Кунай М | 0000000914 | Монгол улсын их сургууль /МУИС/ |
| 6 | Нансалмаа Ш | 0000000915 | Технологийн дээд сургууль /ТДС/ |
| 7 | Наранзаяа М | 0000000900 | Олон улсын эдийн засаг бизнесийн дээд сургууль /ОУЭЗБДС/ |
| 8 | Нямбазар | 0000000920 | Хөдөө аж ахуйн их сургууль /ХААИС/ |
| 9 | Оюунбилэг Ж | 0000000901 | Олон улсын Улаанбаатар их сургууль /ОУУБИС/ |
| 10 | Оюунгэрэл Э | 0000000910 | Эрүүл мэндийн шинжлэх ухааны  их сургууль /ЭМШУИС/ |
| 11 | Оюунцэцэг Б | 0000000904 | Улаанбаатар их сургууль /УБИС-/төрийн өмчийн/ |
| 12 | Сумъяа Р | 0000000903 | Эмзүйн шинжлэх ухааны их сургууль  /ЭЗШУИС/ |
| 13 | Рэнцэндулам Б | 0000000902 | Шинэ Анагаах ухааны их сургууль /ШАУИС/ |
| 14 | Тунгалаг Б | 00000009012 | Соёл урлагийн их сургууль /СУИС/ |
| 15 | Түмэнжаргал Ч | 0000000916 | “Цэцээ гүн” дээд сургууль  /ЦГДС/ |
| 16 | Цэнд-Аюур Ц | 0000000907 | “Этүгин” их сургууль /ЭИС/ |
| 17 | Цэцэгмаа Д | 0000000911 | Монгол улсын Консерваторын их сургууль /МУКИС/ |
| 18 | Энхжаргал Б | 0000000905 | Монголын үндэсний их сургууль /МҮИС/ |

| | | | |
|---|---|---|---|
| 19 | Энхжаргал Д | 0000000908 | Техник технологийн дээд сургууль /ТТДС/- /баазгүй/ |
| 20 | Энхбат Б | 0000000913 | Үндэсний батлан хамгаалах их сургууль /ҮБХИС/ |
| Шинээр эрх нээлгэсэн номын сан | | | |
| 21 | Нарантуяа Ц | 0000000921 | Чингэлтэй дүүргийн лаборатори 23-р сургууль |
| 22 | Шинэтуяа Б | 0000000922 | ХУД-18-р сургууль |
| 23 | Баянмөнх Ц | 0000000923 | Чингэлтэй дүүргийн Номын өргөө |

Дээрх ажлуудыг гүйцэтгэсний дараа төслийн баг хамт олон МУҮНС, Монголын номын сангийн холбоо, БМИҮЗ зэрэг байгууллагууд нийт номын сангуудтай хамтран **“Дээд боловсролын цахим нэгдсэн номын сан”** сургалт, семинар зохион байгуулж төслийн үр дүнг нийтээр зөвлөлдөн хэлэлцэж дүгнэхээр сургалт явуулахаар төлөвлөн амжилттай ажиллаа.

**СУРГАЛТ-III**




**Сургалтын урилга**




**Сургалтын хөтөлбөр**



"ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЦАХИМ НЭГДСЭН НОМЫН САН"
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

**Сургалтын хамрах хүрээ:** Дээд боловсролын номын сан
**Сургалтын хугацаа:** 2019 оны 03-р сарын 13
**Сургалт болох газар:** МУҮНС
**Зохион байгуулагч:** "Дээд боловсролын салбарын цахим нэгдсэн номын сан" төслийн баг
**Сургалтын үйл ажиллагааг хөтлөгч:**
Төслийн нарийн бичиг Ж.Тунгалаг

СУРГАЛТЫН АГУУЛГА

09.00-09.10 Нээлтийн үг: "МУҮНС-ийн бодлого ба сургалт эрдэм шинжилгээний номын сан"-
*Б.Ичинхорлоо /МУҮНС-ийн захирал/*

09.10-09.30 "Дээд боловсролын номын сангийн нийтлэг шаардлага-XXI зуун-
*Ж.Тунгалаг / БМИҮЗ/*

09.30-09.50 "Коха" программын олон улсын ашиглалт"-судалгаа, туршлага.
*Т.Билэгбаатар /ХНС/*

09.50-10.20 "Коха" программыг монголд нутагшуулах ажлын хэтийн чиг хандлага
*Ж.Баатарсүрэн/Консерциум/*

10.20-10.40 "Коха" нэгдсэн санд эх хувиар оруулсан номын зохиогчийн эрхийн хамгаалалт"-
*О.Нарантуяа-/МУИС/*

10.40-11.00 Коха-д "Ном зохиолыг оруулж хадгалах уншуулах боломж"-
*Ж.Эрдэнэзаяа /МУИС/*

11.00-11.20 Цайны завсарлага

11.20-11.40 "Сургалтын материалын цахим мэдээллийн сан бүрдүүлэх арга, туршлага"-
*Т.Лувсанням – /АШУҮИС/*

11.40-12.00 "ESAN"- цахим номын сан — Ц.Одонтуяа /Esan удирдагч/

12.00-12.20 "Дээд боловсролын салбарын ном ангиллын төлөв"- — *Э.Оюунгэрэл –/АШУҮИС/*

12.20-13.00 Асуулт, хариулт-I- — *Ж.Тунгалаг /БМИҮЗ/*

13.00-14.00 Үдийн хоол

14.00 -14.20 "Дээд боловсролын салбарын цахим номын сан"-ийн чиг хандлага" /гадаадын туршлага/ -
*Ж.Цэлэн- /МНСХ-ны тэргүүн/*

14.20-14.50 "МУҮНС дахь Докторын диссертацийг цахимжуулсан арга, туршлага"-
*Ч.Гансүх, Бат.Тунгалаг –/МУҮНС/*

14.50-16.10 "Дээд боловсролын салбарын номын сан хоорондын цахим ном солилцоо-асуудал шийдэл"-
*Н.Мөнхцэцэг- /МУИС/*

16.10-16.50 "Сурах бичиг, гарын авлага, хичээлийн хэрэглэгдэхүүний "ЭСТ" нэгдсэн сан
*Б.Бат-Эрдэнэ –/МУҮНС/*

16.50-17.30 "Коха" нэгдсэн цахим сангаас номын мэдээллийг дэлгэрэнгүй хайх боломж"-
*Г.Баярнуваа- /МУҮНС*

17.30-17.50 Асуулт, хариулт-II – *Б.Бат-Эрдэнэ, оролцогчид*

17.50-18.10 Цайны завсарлага

18.10-18.30 Санал асуулга-III- *Бат. Тунгалаг, Банз. Тунгалаг*

18.30.-19.00 Гарын авлага, сертификат гардуулах, дурсгалын зураг авах-
*Ж.Цэлэн /МНСХ/, Ж.Тунгалаг /БМИҮЗ/*

"Дээд боловсролын салбарын цахим нэгдсэн номын сан" төслийн баг
МУҮНС www.nationallibrary.mn
БМИҮЗ www.accmon.mn
МНСХ: www.facebook.com/MLA

Холбоо барих: 99000159, 89007295
Цахим шуудан: batkalm09@gmail.com

2019 оны 03-р сарын 15-д СУИС-ийн Соёлын сургуулийн 223 тоот лекцийн танхимд “Дээд боловсролын салбарын цахим нэгдсэн номын сан” - Сургалт-III-ын үйл ажиллагаа явагдаж 30 гаруй номын сангийн 70 шахам номын санчид мэдээллийн ажилтан IT инженер-цахим каталогчид оролцов.

**Зураг №25 Сургалтын явцын зураг**



**“Коха”-д мэдээлэл оруулах аргазүйн сургалт-** /эрх авсан номын санчид/



Оролцогчид төслийн үр дүнгийн даалгаварын дагуу хийж гүйцэтгэсэн ажлын төлөв байдал, хүндрэл бэрхшээл, цаашдын чиг хандлагын талаар хэлэлцэв.

**Хүснэгт №3 Төслийн эцсийн үр дүнгийн хэлэлцүүлэг**

| **“ДБСЦННС”-төслийн үр дүн** | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **№** | **Үр дүнгийн даалгавар** | **Хэлэлцсэн асуудал** | **Санал зөвлөмж** | **Үр дүн** | **Гүйцэтгэл** |
| I | **Их сургуулиудын номын сангуудын ном сурах бичиг, гарын авлага, судалгааны ажлын тайлан, хичээлийн хэрэглэгдэхүүний нэгдсэн сан бий болгох** /Номын сангуудын хоорондцахим номын солилцоо хийх боломжтой байхаар/ | “Коха” программыг монголд нутагшуулах ажлын хэтийн чиг хандлага” | Кохагийн нарийвчилсан өгөгдлүүдийг дахин хянах, нэмэлт орчуулгыг хийх | МУҮНС ба их дээд сургуулийн сургалтын баримтууд монгол хувилбартай “Коха”-д нэгдэв | 100 % |
| | | | *Сургалтанд оролцсон номын санчдын 90% монгол хувилбарыг ашиглах боломжийн талаар санал өгөв* | *Төслийн гадуурх зарим номын сангууд англи хувилбартай “Коха”-д орсон* | |
| | | “Сургалтын материалын цахим мэдээллийн сан бүрдүүлэх арга, туршлага” | Сургалтын явцад мэдээллийн санг хэрхэн бүрдүүлэх талаар өгөгдөл тус бүрээр зааж сургав /зураг дээр үз/ | МУҮНС ба 20 их дээд сургуулийн “Эрдэм судлал” нэгдсэн мэдээллийн сантай болов | 29-30 мянган нэгж баримтын мэдээллийн сан үүсгэв. 100% |
| | | “Сурах бичиг, гарын авлага, хичээлийн хэрэглэгдэхүүний “ЭСТ” нэгдсэн сан” | | | |
| | | “ESAN”- цахим мэдээллийн сан” | “ESAN”- нэртэй ХХК байгууллагдан ажиллах болсон тушлагын талаар хэлэлцэв.Зохиогч ийн эрх зөрчигдөх аюултай | Уг компан нь маш чухал асуудлыг хөндсөн. Номоос хуулсан, хулгайлсан асуудлыг илрүүлэх зорилготой программ дээр ажилладаг. | Зохиогчийн гэрээгээр шийдэгдэнэ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| II | **Нэгдсэн сангаас номын мэдээллийг дэлгэрэнгүй гаргах хайлтын систем боловсруулах** /номын нэр, зохиогч, агуулга, гарчиг, судалгааны ажлын өмнөх үг, агуулга гэх мэтийг харах боломжтой болгох/ | “Коха” нэгдсэн цахим сангаас номын мэдээллийг дэлгэрэнгүй хайх боломж” | Гар ажиллагаанаас механик ажиллагаанд шийлжсэн тул номын нэр, зохиогч г.м. бусад мэдээллийг дуудах боломжтой гэж үзэв | “Мэдээлэл номзүйн ажил” хийхэд дэлгэрэнгүй мэдээллийг шууд татаж гаргах боломжтой тул Лавлагаа өгөхөд чухал ажил болсон | 100% |
| III | **Нэгдсэн санд эх хувиар нь цахим хэлбэрт оруулсан номыг хуулбарлах, хэвлэх боломжгүй байх шийдлийг боловсруулах** | “Коха” нэгдсэн санд эх хувиар оруулсан номын зохиогчийн эрхийн хамгаалалт” | Зөвхөн зохиогчтой гэрээ хийж тухайн сургуулийн удирдлага зөвшөөрсөн тохиолдолд эх хувиар оруулна гэж санал нэгтэй хэлэв | МУИС-ийн ахлах номын санч, хуульч О.Нарантуяагийн судалснаар зохиогчийн эрх зохиогчийн гэрээгээр хамгаалагдана. | Сургууль тус бүр зохиогчийн зөвшөөрлөөр ном баримтыг бүтэн эхээр оруулж болно. |
| IY | **Ховор ном зохиолыг цахим хэлбэрт шилжүүлэх, хадгалах, программ хангамжийн болон технологийн хялбар шийдлийг боловсруулах** | “Коха”-д “Ховор ном зохиолыг оруулж хадгалах уншуулах боломж” | “I San”-ХХК-ны удирдагч Ц.Одонтуяа, МУИС-ийн Ж.Эрдэнэням нар энэ асуудлыг тусгайлан хэлэлцүүлэв. Зохиогчийн эрхийн зөвшөөрөлгүй оруулсан номын эрх зөрчигдөх талаар мэтгэлцээн болов | Төслийн хүрээнд “Ховор ном зохиол”-ын нэрсийг гаргуулав” /ЭМШУИС-ийн жишээг хавсралтад/ | Номын сан тус бүр ховор, хуучин гэж үзсэн номын нэрсийг гаргаж журмын дагуу үзүүлэх боломжтой |
| Y | **Ном, бусад хэвлэлүүдийг цахим шуудангаар захиалах, хүлээн авч ашиглах боломжтой захиалгын систем бий болгох** | “Дээд боловсролын салбарын номын сан хоорондын цахим ном солилцоо-асуудал шийдэл” | Бусад сургуулийн номын сангаас цахимаар ном захиалах, очиж унших асуудлыг сургууль хооронд зөвшилцөх нь зөв гэв. | Төслийн хүрээнд сүлжээнд холбогдсон номын сангууд хэрэгцээт ном байгаа эсэх мэдээллийг авах бүрэн боломжтой | МУҮНС-тай холбогдсон сургалт-эрдэм шинжилгээний материалыг эрх авсан НС-100 % |
| | | “Их сургуулийн номын сангийн | Дээд боловсролын номын сангийн | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | онлайн мэдээллийн сангийн тодорхойлолт” | мэдээллийн төрөл, өнөөгийн туршлага, судалгааны нэгдсэн дүнг хэлэлцэж “Цахим мэдээллийн сан”-ийн суурь бүрэн тавигдсан гэж үзэв | | |
| **Цахим номын сангийн судалгаа, туршлага, цаашдын чиг хандлага** | | | | | |
| | **“Цахим нэгдсэн номын сан”-г зохион байгуулж хэрэгжүүлэхэд туслах загвар, туршлга** | “Дээд боловсролын салбарын ном ангиллын төлөв” | Монголын нийт номын сангууд олон улсын ДАА-д нэгдэн орох саналыг бүх номын санчид гаргав | Төслийн хүрээнд МУИС, ҮБХИС-ийн номын сангууд амжилттай орж байна | 100 % |
| | | “МУҮНС дахь Докторын диссертацийг цахимжуулсан арга, туршлага” | “Цахим диссертаци”-ийг номын санч бүр сайшааж, эрх авсан номын санчаар дамжуулан цахим орчинг алдагдуулахгүйгээр мэдээлэл авах нь чухал гэж үзэв | МУҮНС-ийн “Коха” ба цахим диссертаци” гарын авлагыг боловсруулж тараан арга туршлага солилцов | 100 % |
| | | “MARC”-21 форматаар ном, ноотны хэвлэл, газрын зургийн номзүйн мэдээлэл оруулах аргачилал | Ноот, газрынм зураг г.м. өвөрмөц хэлбэртэй бүтээлийг цахимжуулахад энэ загварыг ашиглаж болох талаар ярилцав | 800 гаруй бүтээл цахимжуулсан аргыг гарын авлага болгон тараав | |
| | | “Дээд боловсролын цахим номын сан”-ийн чиг хандлага” /гадаадын туршлага/ | Номын сангийн баримтын мэдээллийг цахимжуулахдаа цаасан мэдээлийн санг устгадаггүй гадаадын туршлагыг зайлшгүй баримтлах нв зөв гэж үзэв | Цаасан мэдээллийн сангийн эх сурвалжийг хадгалж, баяжуулсны дараа цахимд оруулж байх | 100 % |
| | | “Дээд боловсролын номын сангийн нийтлэг шаардлага-XXI зуун” | 1.XXI зууны номын сан нь цаасан суурин дээр цахимжих шинжтэйг судалгаа, туршлага харуулж байна;<br>2. Аль ч улсын үндсэний номын сан нь мэдээллийн төв байна;<br>3. Цахим номын сангийн техник, программ хангамжийг тусгай компани, баг хамт олон | | |

| | | |
|---|---|---|
| | | хариуцаж, цахим мэдээллийг хадгалж хамгаалах технологийг сайжруулах;<br>4.Дотоод гадаадад мэдээлэл солилцоход номын сангийн мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэсэн бодитой, стандартын бичилттэй өгөгдлүүд чухал;<br>5. “ДБСЦННС” төсөл ийм цаг үед хэрэгжиж байгаа нь цаг үеийн чухал эхлэл боллоо; |

Эцсийн хэлэлцүүлгийн үеэр дээд боловсролын номын сангуудын эрэлт хэрэгцээ, лавлагаа мэдээллийн сан, төслийн үйл ажиллагааны талаар **“Дээд боловсролын салбарын цахим нэгдсэн номын сан”** нэртэй социологийн судалгаа авч дүгнэж үзсэн билээ.

**Социологийн судалгааны асуулга №5**

8248214 1117245111 MLA

**БАТЛАВ: Төслийн удирдагч Доктор** [signature] **Ж.Цээн**

**“ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЦАХИМ НЭГДСЭН НОМЫН САН” - төслийн судалгаа №5**

Энэхүү судалгааны зорилго нь төслийн үр дүн, цаашдын зорилтыг тодорхойлох юм.

1. Танай номын санд Үндэсний номын сан болон бусад номын сангуудаас эрхлэн гаргасан номзүйн бүртгэлүүд хангалттай байдаг уу?
   а/ Тийм
   б/ Үгүй
   в/ Мэдэхгүй...............................
2. Лавлагаа өгөхдөө ямар эх сурвалжийг голчлон ашиглаж байна вэ?
   а/ Хэвлэмэл номзүйн бүртгэлүүд
   а/ Электрон каталог, картын сан
   б/ Уламжлалт каталог, картын сан
   в/ Цахим мэдээллийн сангууд /нэрсийг нь бичнэ үү?
   ..........................................................................................................
   г/ Интернет эх сурвалж
3. Танай номын санд Цахим мэдээллийн сангийн эрэлт хэр их байна вэ?
   ..........................................................................................................
   ..........................................................................................................
4. Энэхүү нэгдсэн санд цаашид бүх номын санг нэгтгэх шаардлага байна уу?
   а/ Зайлшгүй шаардлагатай
   б/ Шаардлагагүй
   в/ Мэдэхгүй
   г/ .........................................................................................
5. Төслийн талаарх Таны сэтгэгдэл?
   ..........................................................................................................
   ..........................................................................................................
   ...............................................
6. Танд энэхүү сургалт үр дүнтэй байж чадав уу? /Хэрвээ тийм бол аль сэдвийг гүнзгийрүүлэн судлах хүсэлтэй байна вэ? Үгүй бол яагаад?/
   а/ Тийм ............................................................................
   б/ Үгүй ............................................................................

***ТАНД БАЯРЛАЛАА!***

**“Дээд боловсролын салбарын номын санчдын санал, үзэл баримтлалд хийсэн судалгаа, дүгнэлт №5**

**Нэг. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:** Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Номын сангийн тухай хууль, Шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх журмыг үндэслэн хийсэн “Дээд боловсролын салбарын цахим нэгдсэн номын сангийн төсөл” хэрэгжсэнтэй холбогдуулж сургалтанд оролцсон 64 номын санч инженерүүдээс “Эрдэм судлалд туслах цахим сан”д нэгдсэн 20 сургуулийн 24 номын санчийн дунд 2019 оны 03 сарын 15- ны өдөр энэхүү судалгаа явуулав.

**Ажлын хэсэгт:** Монгол Улсын Үндэсний номын сангийн захирал Б. Ичинхорлоо, Дээд боловсролын номын сангийн холбооны тэргүүн Ж. Цэзэн, Дээд боловсролын Магадлан итгэмжлэх Үндэсний зөвлөлийн мэргэжилтэн Ж. Тунгалаг, Монгол Улсын Үндэсний номын сангийн Сан хөмрөг хадгаламжийн хэлтсийн дарга Б. Тунгалаг, номзүйч Б. Бат-Эрдэнэ, номзүйч Г. Баяртуяа нар ажиллав.

**Хоёр. Ажлын хэсгийн дүгнэлт, санал**

Дээд боловсролын төсөлд хамрагдаж хамтран ажилласан 20 сургууль номын санч мэдээллийн ажилтнууд, инженерүүдээ өргөнөөр хамруулсан явдал санал асуулгаас бодитой дүгнэлт хийх бололцоо олгосон. Санал асуулгад оролцогчдын өгсөн саналын ихээс бага руу эрэмбэлэн дараах дүгнэлтийг хийж байна:

1. **“Танд энэхүү сургалт үр дүнтэй байж чадав уу? Хэрвээ тийм бол аль сэдвийг гүнзгийрүүлэн судлах хүсэлтэй байна вэ?** гэсэн асуултанд тийм гэж 24-**21** хамгийн их санал авсанаас үзвэл энэхүү төслийн сургалт нь цагаа олсон, дээд боловсролын сургалтын байгууллагын номын санч инженерүүдийн хүсэн хүлээж байсан, нэн шаардлагатай сургалт болжээ гэж үзэж байна.

2. “**Төслийн талаарх Таны сэтгэгдэл**” гэсэн асуултанд 24-**20** удаах олон санал буюу **Их мэдээлэл авч маш хэрэгтэй ажлыг эхлүүллээ** гэж хариулсанаас үзвэл Номын сангуудаас ирсэн төлөөлөл бүгд Нэгдсэн сүлжээний ач тусыг ойлгож хамтарч ажиллахыг хүсэж байгаа нь харагдлаа.

3. **“Энэхүү нэгдсэн санд цаашид бүх номын санг нэгтгэх шаардлага байна уу?** гэсэн асуултанд 24-**19** санал өгчээ. Нэгдсэн санд бүх номын санг нэгтгэснээр

Номын санчдын ажил хөдөлмөрийг хөнгөвчилж олон номын санд байгаа ижил хувьтай номуудыг нэг газар нэг л удаа шивж оруулах хэрэгтэйг энэ санал онцолжээ.

4. **“Лавлагаа өгөхдөө ямар эх сурвалжийг голчлон ашиглаж байна вэ?”** гэсэн асуултад “Хэвлэмэл номзүйн бүртгэлүүд”-8, **Электрон каталог, картын сан-17,** Уламжлалт каталог, картын сан-6, Цахим мэдээллийн сангууд нэрсийг бичнэ үү гэсэн асуултанд **Электрон каталог картын сангаас** ашиглаж лавлагаагаа өгдөг гэж 17 нь хариулсанаас үзвэл Цахим нэгдсэн мэдээллийн сан нэн хэрэгцээтэй байгааг улам их чухалчилж байна.

5. “**Танай номын санд Цахим мэдээллийн сангийн эрэлт хэр их байна**” вэ? гэсэн асуултад Их -**13,** Сайн биш-**7,** Мэдэхгүй-**2** гэсэн хариултаас харахад уншигч судлаачдын ихэнх хувь нь цахим мэдээллийн санг ашиглаж хэрэгтэй номоо олж авахыг хүсэж байгааг харуулж байна.

6. “**Танай номын санд Үндэсний номын сан болон бусад номын сангуудаас эрхлэн гаргасан номзүйн бүртгэлүүд хангалттай байдаг”** уу**?** гэсэн асуултад Тийм-**8**, Үгүй- 13, Мэдэхгүй-3 гэж хариулжээ. Энэ нь номын сангуудын лавлагаа мэдээллийн санд шаардлагатай номзүйн бүртгэлүүд дутмаг, нөхөн бүрдүүлэх хэрэгтэй байгааг сануулж байна.

**Нэгдсэн дүгнэлт:**

Тоон статистикийн болон санал асуулгад оролцогчдын өгсөн хариултын өгөгдлүүдийн жигнэсэн дунджийн аргаар боловсруулсан бидний ажлын дүн мэдээнээс харвал Улс орон даяар номын сангуудын Цахим мэдээллийн сангийн эрэлт хэрэгцээ ихсэж, Нэн чухал шаардлагатай үед “Дээд боловсролын салбарын цахим нэгдсэн номын сан” төсөл хэрэгжиж төслийн хүрээнд ганцаарчилсан болон нийтийн сургалтууд удаа дараа явагдаж, нэгдсэн нэг програмтай, нэг сүлжээнд орохын эхлэл тавигдсан нь үйл ажиллагааг улам сайжруулж эхлүүлсэн ажлыг тасралтгүй явуулах шаардлагатайг харуулж байна гэж манай ажлын хэсэг үзсэн болно.

АЖЛЫН ХЭСЭГ:2019.3.15

## ТӨСЛИЙН ТАЙЛАН ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ЯВЦЫН ДҮН

/Төслийн тайлангийн явц, давуу сул тал, бэрхшээл, санал, дүгнэлт/

* Төслийн хугацаанд ажлын явцын тайланг 3 удаа биетээр илтгэн хэлэлцүүлэв. Үүнд:

**Нэг**. 2017 оны 06-р сарын 14-д МУҮНС дээр БСШУСЯ, ШУТС-ийн төсөл хариуцагч 5 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид, төслийн багийн гишүүдэд төслийн явцын талаар илтгэн хэлэлцүүлэв.

**Өгсөн зөвлөмж:**

*ШУТС-ийн мэргэжилтний зүгээс төслийг ерөнхийд нь сайшааж, санал зөвлөмж өгөв. Үүнд:*

*а/ Төслийн хүрээнд хийсэн гарын авлага, зөвлөмжүүдийг төслийн санхүүжилтээр хийсэн гэж заавал тэмдэглэх;*

*б/“Коха” программыг анх монголд нэвтрүүлсэн Н.Мөнхцэцэг зэрэг хүмүүсээс зөвлөгөө авах /Ганчимэг, Л.Батдэлгэр/*

*в/ Санхүүгийн тайланг тодорхой болгох*

**Хоёр:** 2018 оны 12-р сарын 18-д МУҮНС дахь “Цахим диссертаци” –ийн 11.577 мэдээллийн санг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөх хэлэлцүүлэг хийв. БСШУЯ, ШУТС-с 6 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид оролцлож санал зөвлөмж өгөв:

**Өгсөн зөвлөмж:**

*а/ Монгол улсад 100 жилийн хугацаанд эрдмийн зэрэг хамгаалсан цаасан диссертацийн мэдээллийг цахимжуулсан явдал улс орны дотоод гадаадад маш их ач холбогдолтой ажил болсныг ШУТС+ийн мэргэжилтэн нар сайшаан тэмдэглэв.*

*б/ Төслийн ажлыг хугацаандаа гүйцэтгэж тайлагнах, санхүүгийн тайланг гаргаж нэгтгэж ирүүлэхийг ШУТС-ийн захирал-/Д.Энхжаргал/, санхүү-/Б.Отгонжаргал/, төслийн явц, тайланд зөвлөгч-/Д.Наранцацрал/, БСШУСЯ-ны төсөл хариуцсан мэргэжилтэн Г.Оюунцэцэг нар МУҮНС-ийн захирал Б.Ичинхорлоод санал болгов*

*в/ МУҮНС-ийн захирал Б.Ичинхорлоо хэлсэн үгэндээ: энэхүү ажлын гүйцэтгэлийг дэмжиж, олон хүний хүч оролцоогоор, хямд үнэ өртгөөр нүсэр их ажил хийсэнд төслийн удирдагч Ж.Цэзэн болон баг хамт олонд, мөн санхүүжүүлэгч байгууллагын төлөөлөгчдэд талархал илэрхийлэв.*

*г/ “Цахим диссертацийг цаашид сайтар нягтлан шүүж, алдаа мадгийг засах, үргэлжлүүлэн цахимжуулах ажлыг төслийн удирдагч профессор (Sc.D) Ж.Цэзэн МУҮНС-ийн захирал, хамт олонд санал болгов.*

**Гурав:** 2019 оны 01-31-д БСШУСЯ, ШУТС-ийн захиалгат төслийн баг хамт олонд “ДБЦННС” төслийн явц, үр дүнгийн талаар төслийн удирдагч Ж.Цэзэн, Их дээд сургуулийн цахим мэдээлэл хариуцагч МУҮНС-ийн мэргэжилтэн Б.Бат-Эрдэнэ нар БСШУСЯ- дээр илтгэн танилцуулж хэлэлцүүлэв.

**Өгсөн зөвлөмж:**

*а/ Тайлан ерөнхийдөө сайн болсон байна хугацаандаа бичиж хүлээлгэж өгөх, хэрэв сунгах саналтай бол 6 сараар сунгаж болно, яамны ШУТБГ-д албан тоот өгөх;*

*б/ Дараагийн хэлэлцүүлэгт санхүүгийн тайланг дэлгэрэнгүй бичиж хариуцсан нягтланг биеэр оролцуулах;*

**Мониторингийн тайлан:**

Төслийн мониторингийн тайланг улирал бүр бичиж ШУТС-д цаасан болон цахим хэлбэрээр тайлагнав.

а/ Төслийн дэлгэрэнгүй тайланг 2 удаа, томилолтын тайланг 1 удаа бичиж ШУТС-д хүлээлгэж өгөв.

б/ Төслийн үр дүнгийн нэгдсэн тайланг боловсруулан бичиж ШУТС болон БСШУСЯ-ны захиалгат төслийн багт танилцуулах, засварлах, хүлээлгэн өгөх, төсөл дуусгах шат дараалсан ажлуудыг хийж гүйцэтгэв.

в/ Төслийн санхүүгийн тайланг 2017, 2018 он тус бүрээр болон нэгдсэн тайланг боловсруулан гаргаж хэлэлцүүлэх, хүлээлгэн өгөх ажлыг МУҮНС-ийн нягтлан бодогч Э.Энхзул хариуцан хийснийг тэмдэглэж байна

## ТӨСЛИЙН НЭГДСЭН ДҮГНЭЛТ

/Төслийн үйл ажиллагааны нэгдсэн дүгнэлт, санал, зөвлөмж, цаашдын чиг хандлага/

**I. Олон улсын номын сангийн цаашдын чиг хандлага**

1. Дэлхий нийтээр **"цахим номын сан"**-нд бүрэн шилжих төлөв хандлагатай байна;
2. **"Цахим ном**"- ыг алслагдсан орон зайнаас унших уншлагын сонирхол дэлхий нийтэд ижил өсөж байна;
3. **"Цахим номын сан"**-г хөгжүүлэхэд инженер техникийн мэргэжлийн баг хамт хамтран ажиллах жишиг олон улсад тогтсон байна;
4. Олон улсын туршлагаас үзвэл тухайн улс орны **"Үндэсний номын сан"** тэргүүлэх үүрэгтэй байна;
5. Дэлхий дахинаа Номын сангууд нэгдэж, нэг индекс, код бүхий стандартыг баримталж мэдээлэл солилцох тогтолцоонд орж байна

**II. Санал:**

Иймд **"Монголын цахим нэгдсэн номын сангийн тогтолцоог буй болгож, олон улсад нэгдэх шаардлагатай.** Үүний тулд дараах төрлөөр ажиллах саналыг дэвшүүлж байна:

1. Монгол улсын нийтийн номын санг цахимжуулах;
2. Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн номын санг цахимжуулах
3. Эрдэм шинжилгээний хүрээлэн, байгууллага бусад номын санг цахимжуулах ажлыг энэхүү төслийн загвараар үргэлжлүүлэхийг бодлогоор дэмжих, олон улсын номын сангийн стандарт норм нормативыг нийтээр нэвтрүүлж баримтлах

**III. Зөвлөмж:**

**Нэг. "Монголын номын сангийн цахим нэгдсэн сүлжээг**" жигд хөгжүүлэхэд **"Монголын номын сангийн холбоо"** -ны үйл ажиллагааг дэмжин хамтарч ажиллах нь гадаад улс орны туршлагатай нийцэж байна.

Төслийн хүрээнд хийгдсэн үндсэн үр дүнгийн даалгаварт ажлаас гадна цаашид чухал шаардлагатай дараах ажлыг санаачлан эхлэлийг тавьж ажиллаа. Энэ нь номын санчдад аргазүйн зөвлөмж өгөх, мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд чухал юм.

1. **“Мэдээллийн сан бүрдүүлэх”** аргыг зааж сургах шат дараалсан мэдлэгийг “Чадамжийн сургалт”-нд тулгуурлан хөгжүүлэх асуудлыг эхлүүлжсэн нь номын санч бие дааж цахим ажиллагаанд суралцахад тустай.
2. Дээд боловсролын салбарын болон бусад номын сангуудад аккертаци, магадлан итгэмжлэл, номын санчийн зэрэглэл тогтоох талаар баримт бичиг боловсруулан, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах ажлын эхлэл тавигдсан нь номын санчийн хөгжилд ач холбогдол өгнө.
3. “Монголын номын сангийн “Арван ухаан” холбооны сан хөмрөгт хуримтлагдсан 10 нэр төрлийн 50,000 нэгж мэдээлэл бүхий цаасан картын санг цахимжуулах ажлыг төслийн хүрээнд эхлүүлэв. Зарим шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийг (Хавсралтанд баримтыг үзнэ үү) ашиглаж эхэлснээр НСХ-ны үйл ажиллагаанд ахиц дэвшил гарч байна
4. Номын сангийн холбооноос олон улсын түвшинд нэгдэн ажиллах /ДАА/ нэг ангилал, индекс, кодыг нэвтрүүлж ном, гарын авлагаар хангаж байна.
5. Цаашид дадлага туршлагад суурилсан төрийн бодлого дэмжлэг, төсөл хөтөлбөрөөр тулгамдсан асуудлыг хамтран шийдвэрлэх нь зөв зүйтэй гэж зөвлөж байна.